

ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2021 ОНЫ 04 ДҮГЭЭР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

2020 оны 04 дүгээр сарын 30

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2021 оны 04 дүгээр сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, Ажлын албанаас 2021 оны 4 дүгээр сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 4-р хуралдаан 4-р сарын 08-нд хуралдаж 10 асуудал хэлэлцэн, 8 тогтоол баталж, хуралдааны 3 тэмдэглэлээр үүрэг өгөв.

- Тэргүүлэгчдийн IV Хуралдаанаар:

1.Төв аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, шинэ гишүүдийг томилох тухай асуудлыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүрэг бүхий Иргэний зөвлөлийн 5 гишүүнийг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс чөлөөлж, шинээр томилогдох иргэний зөвлөлийн гишүүдийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахыг Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргад даалгав.

2.Олон хүүхэд төрүүлж өсгөж “Эхийн алдар” нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнуулах хүсэлт уламжлах тухай асуудлыг хэлэлцээд “Эхийн алдар” нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнагдах болзол хангасан аймгийн 27 сумын “Эхийн алдар” нэгдүгээр одонгоор 31, “Эхийн алдар” хоёрдугаар одонгоор 361 нийт 392 эхчүүдийг шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.

3. “Сонгодог урлаг-III” аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцээд “Сонгодог урлаг-III” аймгийн дэд хөтөлбөрийн үр дүнг сайжруулж, иргэд олон нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэхэд чиглүүлэх, мэргэжлийн урлагийн байгууллагад нэн шаардлагатай найруулагч, концертмейстерийн ажлын байрыг нийтэд зарлаж тогтвор суурьшилтай ажиллуулах талаар анхаарч ажиллах, хөтөлбөрийг **иргэд, хүүхэд залуучуудад** сурталчлан таниулах **арга хэмжээг өргөнөөр зохион байгуулах**, “Сонгодог урлаг-III” аймгийн дэд хөтөлбөрийн удаашралтай байгаа зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргад даалган хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

4. Аймгийн хаврын тариалалтын бэлтгэл ажлын явцыг хэлэлцээд Хаврын тариалалтад дутагдаж буй 8116 тонн үр тарианы үрийг яаралтай Улсын нөөцийн болон Хөдөө аж ахуйг дэмжих санд хандаж татан авалт хийх, иргэн, аж ахуйн нэгжүүдэд хүртээмжтэй хуваарилуулах хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, Төв аймгийн хэмжээнд цар тахал халдварлан тархаж байгаатай холбогдуулан хаврын тариалалтыг цаг хугацаанд нь эхлүүлэх зорилгоор тариаланчдыг вакцинжуулалтад бүрэн хамруулах ажлыг нэн тэргүүнд зохион байгуулах, Газар тариалангийн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгохтой холбоотой бэлтгэл ажлыг бүрэн хангаж, тооцоо судалгаа хийн холбогдох газарт уламжлах, Тариаланчдад шаардлагатай зээл, тусламжаар хангах талаар онцгой анхаарч, мэдээллийг сумдын тариалалтын штаб сумын Хөдөө аж ахуйн мэргэжилтэнээр зэргээр дамжуулан цаг алдалгүй хүргэх, Тариалалтын өмнөх боловсруулалт, /үүлэнд нөлөөлөх/ ажлыг хийх, тариалангийн талбайн нөөц чийгийн судалгааг зохих хугацаанд хийлгэж, тариаланчдад мэдээлэн шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргад даалган хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

5.Зуунмод сумын дахин төлөвлөлт, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны талаар мэдээллийг хэлэлцээд Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган

шинээр барих төслийн хүрээнд Зуунмод сумын 1-р багт 3, 4, 5-р байр-2000 м², 31, 32, 33-р 2000м², 15-р байр 1300м², Мал эмнэлэг, үржлийн байр орчмын 3031 м² газарт төсөл хэрэгжүүлэх байршлыг тогтоож, Зуунмод хотын 1-р баг, 1, 2, 34, 35, 36-р байр орчмын ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төсөл хэрэгжүүлэгч “ПГС” ХХК-ний баригдаж байгаа 40 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулж, бусад төлөвлөгдсөн орон сууцны хэсгүүдэд дахин төсөл сонгон шалгаруулалтыг хууль, журмын хүрээнд зарлан төсөл хэрэгжүүлэх, дахин төлөвлөлтийг зохион байгуулах ажлын хэсгийг шинэчлэн, дахин төлөвлөлтийн талаарх мэдээллийг иргэдэд сайтар хүргэж, харилцаат мужуудтай хамтран хэрэгжүүлэх, дахин төлөвлөлтийг цогцоор нь шийдэж орчны тохижилт зам, талбай амрах орчин бүрдүүлэн хорооллын хэлбэрээр зохион байгуулахыг аймгийн Засаг даргад даалгав.

6. Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж барих, засварлах бүтээн байгуулалтын ажилд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрхийг төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч хуулийн этгээдэд олгох журам батлах тухай асуудлыг хэлэлцээд Хурлын Байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хороонд шилжүүлэв.

7. Аймгийн “Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр төлөвлөгөө”-ний нэгдүгээр үе шатны явцын тухай мэдээлэл, тайланг хэлэлцээд аймгийн “ Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр төлөвлөгөө”-г аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 80 дугаар тогтоолоор 5 зорилт 36 хэрэгжүүлэх арга хэмжээтэй батлан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, эрх зүйн орчин боловсронгуй болгох зорилгоор 2019-2020 онд “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах сэргээн ашиглах, устгах, булшлах журам”, “Хог хаягдлын менежментийг сайжруулсан иргэн, ААНБ-ыг урамшуулах журам”-уудыг, аймгийн ИТХТ-ийн тогтоолоор, “Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон Хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам”-ыг аймгийн Засаг даргын захирамжаар тус тус батлан мөрдүүлж байна. Хог хаягдлыг бууруулах ажлыг үе шаттай зохион байгуулах ажлын хүрээнд 2017 онд 8, 2018 онд 10, 2019 онд 8, 2020 онд 8 сумд хогийн цэгүүдээ хашаажуулах, төвлөрсөн хогийн цэгийн эзлэх талбайн хэмжээг багасгах түрэлт булалтыг нийт 40,5 га талбайд зохион байгуулж, эргүүлэн ашиглах талбай гаргасан байна.

Тус хөтөлбөр төлөвлөгөө хэрэгжүүлэх хугацаанд сумд жил бүр 5-10 удаагийн нийтийн цэвэрлэгээ зохион байгуулж, давхардсан тоогоор 5660 аж ахуйн нэгж байгууллага, 88996 иргэн хамруулан нийт 28,6 мянган тн хог хаягдал цэвэрлэж 147,1 сая төгрөг зарцуулжээ.

Техник шинэчлэлийн хүрээнд 2017-2020 онд Зуунмод, Дэлгэрхаан, Баян, Баян-Өнжүүл, Баянцагаан, Батсүмбэр, Эрдэнэ, Эрдэнэсант, Мөнгөнморьт зэрэг 9 суманд 12 хог тээвэрлэх машин, Аргалант, Баянцагаан сумдад хог хаягдлын түрэлт багасгалт хийх техник /ковш/ шинэчлэл тус тус хийж нийт 457,8 сая төгрөг зарцуулсан байна.

Хог хаягдлын талаар холбогдох хууль, иргэдийн эрх үүргийг сурталчлан таниулж хүүхэд залуучуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтыг жилд 2-3 удаа зохион байгуулж 18186 иргэн хамруулан, 6463 ширхэг гарын авлага зөвлөмжөөр хангаж ажилласан байна гэж үзэн аймгийн “Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр төлөвлөгөө”-ний хэрэгжилт 83,4 хувьтай тул “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэв.

Аймгийн “Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2 дахь шатны төлөвлөгөөг шинэ санал санаачилга, дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэх иргэд болон Тэргүүлэгчдээс гарсан саналыг тусган боловсруулж 2021 оны II улиралд багтаан аймгийн ИТХ-аар батлуулж, хэрэгжилтийг жил бүр тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгав.

8. Ойн сангаас мод шилжүүлэн суулгах төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай асуудлыг хэлэлцээд тус асуудлыг Тэргүүлэгчдийн Хуралдаанд дахин танилцуулахаар буцаав.

9. Хөрөнгө шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцээд акталж устгах, худалдах, шилжүүлэх барилга, дуудлагын худалдаагаар худалдах тээврийн хэрэгсэл, балансаас балансад шилжүүлэх тээврийн хэрэгсэл, акталж устгах тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын жагсаалтыг тус тус батлан

дуудлагын худалдааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, төлбөрийг аймгийн төсөвт бүрэн төвлөрүүлэх, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган Төрийн болон орон нутгийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд бүртгэх, акталж устгах тоног төхөөрөмж, тавилга эд хогшилыг байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад зохион байгуулахыг аймгийн Засаг даргад даалгав.

Тус тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Хурлын 2012 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 104 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 18,19,20 дахь заалтыг хүчингүйд тооцов.

10. Төрийн дээд одон медальд уламжлах тухай асуудлыг хэлэлцээд Төв аймгийн эдийн засаг, нийгэм, хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэндийн салбарын хөгжилд авъяас билэг, хүч хөдөлмөрөө дайчлан олон жил, үр бүтээлтэй ажиллаж, залуу хойч үеийг өөрийн арга туршлагаар залгамжлан хүмүүжүүлж байгаа дараах иргэдийг төрийн дээд одон медаль болох “Гавъяат багш цол”-оор 1, “Гавъяат холбоочин цол”-оор 1, “Гавъяат дасгалжуулагч цол”-оор 1, “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-оор 6, “Алтан гадас одон”-оор 37, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар 30 иргэдийг тус тус шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 4 дүгээр Хуралдаанаар 10 асуудал хэлэлцэж 8 тогтоол, хуралдааны тэмдэглэлээр 3 үүрэг өгөв.

Аймгийн ИТХ-ын Ажлын албаны хүрээнд: 4 дүгээр сард аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд хандсан 27 албан бичиг ирснийг бүртгэн авч хариу хүргүүлэх шаардлагатай 3 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна. Аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд хандан иргэдээс ирсэн өргөдөл гомдол бүртгэгдээгүй байна.

Аймгийн ИТХ-ын дарга, Хурлын Ажлын албанаас УИХ-ын гишүүд, Ерөнхийлөгчийн тамгын газар, салбарын яамдад болон холбогдох албан байгууллагад 25 бичгийг гарган хүргүүлж ажиллалаа.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба нь УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төсөлтэй хамтран 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 04 дүгээр сарын 12-ны өдрүүдэд 27 сумын ИТХ-ын төлөөлөгч нарт сургалт зохион байгуулж ажиллалаа.

Сумдын ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан сургалтад сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нар, төлөөлөгчид хамрагдсан бөгөөд 27 сумын нийт 541 төлөөлөгчдийн 85 хувийг хамруулж анх удаа сонгогдсон 277 төлөөлөгчийг хамрагдлаа.

Сургалтыг Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Захиргааны ерөнхий хууль, орон нутгийн төсвийн удирдлага, байгаль орчны төлөвлөлт, санхүүжилт сэдвээр явагдсан бөгөөд орон нутгийн сонгуулийн үр дүнгээр шинээр сонгогдсон Төлөөлөгч нарт хууль эрх зүйн мэдлэг олгох, тэднийг чадавхжуулах, сумын ИТХ-д хуулиар олгогдсон эрх үүргийг хэрэгжүүлэхэд ИТХ-ын төлөөлөгчдөд шаардлагатай суурь мэдлэгийг олгох, практикт гарч байгаа хүндрэлийг шийдвэрлэх арга замыг хэлэлцэх арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор хийлээ.

Аймгийн ИТХ-ын Ажлын албанаас Төв аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Иргэний зөвлөлийн гишүүнээр оролцох хүсэлт ирүүлсэн 17 иргэний материал хүлээн авч, шаардлага хангасан 16 иргэнд санал авах ажиллагааг 03-р сарын 03-аас 04-р сарын 02-ны өдөр хүртэл цахим хэлбэрээр зохион байгуулсан.

Аймгийн ИТХ-ын даргын 2021 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 02 дугаар захирамжаар ИТХ-ын дэргэдэх “Иргэний зөвлөл”-ийн гишүүдийг Сонгон шалгаруулах комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж сонгон шалгаруулах комисс 2021.03.05-ны өдөр хуралдаж ирүүлсэн материалыг шалган Цагдаагийн албаны тухай хуулийн 62.3 дахь заалтын дагуу “Иргэний зөвлөл”-ийн гишүүнээр сонгогдож болохгүй *лулс төрийн албан тушаал эрхэлж байсан*/ үндэслэлээр иргэн

С.Өлзийдэлгэрийн материалыг хасч, 16 иргэнийг 2021.03.04-2021.04.02-ны өдрийн хооронд иргэдээс “Google forms”-оор санал авахаар шийдвэрлэсэн.

“Google forms”-оор санал авахдаа нэг email хаягаас зөвхөн нэг санал өгөхөөр тохируулга хийн зохион байгууллаа. Санал авах хугацаанд нийт 740 email хаягаас иргэний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч иргэдэд санал өгсөн байна.

Санал авах ажлыг зохион байгуулахдаа ИТХ-ын дэргэдэх “Иргэний зөвлөл”-ийн үйл ажиллагааны талаар дүгнэлт өгөх байдлаар заавал сонгох төлөвтэй оруулсан бөгөөд санал авах ажиллагааны дүн, иргэний зөвлөлийн гишүүдийг шинээр томилох асуудлыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 4-р хуралдаанаар хэлэлцүүлж аймгийн ИТХ-ын 6 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.

Аймгийн ИТХ-ын ажлын албанаас улс орон даяар корона вируст цар тахлын халдвар нэмэгдэж байгаа хүнд үед Ажлын албаны албан хаагчид 2 өдрийн цалингаараа дархлаажуулалтыг дэмжих чин сэтгэлийн аян зохион байгууллаа.

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин, хөл хорионд байгаа өрхийн орлого багатай зорилтот бүлгийн 15 өрхийн 42 хүүхдэд нэг сая орчим төгрөгийн халдвар хамгааллын хэрэгсэл, дархлаажуулалтын багц бэлэглэлээ.

Ковидгүй улс орон, аймаг, сум, өрх гэр бүл, хувь хүний төлөө халдвар хамгааллын дэглэмээ баримтлан, дархлаагаа дэмжиж, тусламж шаардлагатай нэгэндээ дэмжлэг үзүүлэхийг аймгийн ИТХ-ын Ажлын албанаас уриалга дэвшүүлэн ажиллаж байна.

2021 оны 4-р сарын 15-ны өдөр орон нутгийн удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгууллаа.

Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын болон бүх шатны Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө, “Хүний Хөгжил-Эрүүл Мэндийг Дэмжих” урианы жилийн ажлын төлөвлөгөө болон бусад баримт бичгийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг болохуйц арга зүйн мэдээлэл зөвлөгөө мэдээлэл өгөх зорилгоор 27 сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, ИТХ-ын Нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга, Багийн Засаг дарга, Төсөвт Байгууллагын удирдлагад арга зүйн мэдээлэл өгч цахим сургалт зохион байгуулж тус сургалтад аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн, нарийн бичгийн дарга Ч.Жавзанпагма нар оролцож холбогдох үүрэг чиглэл өгсөн.

4-р сарын 22-ны өдөр аймгийн үр тариа үйлдвэрлэгчдийн тариалалтын зөвлөгөөн цахимаар зохион байгуулагдаж орон нутгийн “ТӨВ” телевизээр шууд дамжуулж иргэдэд хүргэлээ.

УИХ-ын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь төсөл”, Удирдлагын академи, Төв, Хэнтий аймгуудын ИТХ-ын Ажлын алба хамтран тус 2 аймгийн Төлөөлөгчдөд 04-р сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Сургалт нь орон нутгийн төсвийн удирдлага, Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн үндэс, үйл ажиллагаа, Байгаль хамгаалах газрын харилцаа-ИТХ, иргэдийн оролцоо сэдвийн хүрээнд явагдан Төв аймгийн ИТХ-ын 36 төлөөлөгч оролцлоо.

Аймгийн ИТХ-ын Ажлын албанаас ковидгүй улс орон, аймаг, сум, өрх гэр бүл, хувь хүний төлөө халдвар хамгааллын дэглэмээ баримтлан, дархлаагаа дэмжиж, тусламж шаардлагатай нэгэндээ дэмжлэг үзүүлэх талаар УРИАЛГА дэвшүүлэн ажиллаж байгаа бөгөөд тус уриалгад аймгийн ИТХ-ын төлөөлөгчид нэгдэн хаваржилт хүндэрч байгаа үед Зуунмод сумаас аймгийн ИТХ-д сонгогдон ажиллаж буй 7 Төлөөлөгчид хамтран Зуунмод сумын 6 багийн малчин өрхөд нийт 7,000,000₮ төгрөгийн үнэ бүхий өвс тарааж өгөн ажиллаж байна.

Төв аймагт 4-р сарын 24-ний өдрөөс эхлэн эхний ээлжийн дархлаажуулалтад хамрагдсан Эмнэлгийн мэргэжилтнүүд, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналт, Цагдаагийн албан хаагчид, Аймгийн онцгой комиссын гишүүд, Аймгийн стратеги бүхий байгууллагын албан хаагчид дархлаажуулалтын 2-р тунд хамрагдах ажил зохион байгуулагдлаа.

Эрүүл мэндийн яамнаас Төв аймаг 2-р тунгийн 5901 вакцины татан авалт хийсэн бөгөөд 2-р тунд хамрагдах иргэдийн вакциныг 27 сумдад хүргэх ажлыг зохион байгуулан сумдад хүргээд байна.

2021 оны 4-р сарын 08-ны өдөр “Төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь төсөл”, аймгуудын ИТХ-ын нэгдсэн khural.mn цахим хуудасны хөгжүүлэлтийг шинээр хийж буй Онлайн слюшенс ХХК-ны зүгээс цахим хуудасны шинэ хөгжүүлэлтийн талаарх сургалтад аймгийн ИТХ-ын ажлын албаны 2 мэргэжилтэн болон 27 сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга нар хамрагдсан.

Аймгийн ИТХ-ын tov.khural.mn сайтын шинэ хөгжүүлэлтэд 2020 оны аймгийн ИТХ, Тэргүүлэгчдийн тогтоолоос байршаагүй үлдсэн тогтоол, 2021 оны Хурлын хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралдаанаас батлагдсан тогтоол шийдвэрүүд, аймгийн ИТХ, Тэргүүлэгчид, Ажлын албанаас хийж гүйцэтгэж буй мэдээ мэдээлэлүүдийг шинэчлэн байршуулж ажилласан байна.

Аймгийн ИТХ-ын Ажлын албанаас 27 сумдын дэд цахим хуудасны баяжилтийг хийх талаар цахим хуудас хариуцсан админуудад сургалтын дагуу холбогдох зааврыг өгч сумдын цахим хуудасны баяжилтын ажил хийгдэж байна.

Авлигатай тэмцэх газраас аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөд авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, нийтийн албан тушаалтныг авлигын эсрэг соён гэгээрүүлэх, чадавхжуулах замаар авлигаас урьдчилан сэргийлэх сургалтын сургагч багш бэлтгэх сургалтад аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтан А.Батцэцэг, А.Батзаяа нар хамрагдав.

Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:

Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд:

Аймгийн Засаг даргын 2021 оны А/229 дүгээр захирамжаар “Орон нутгийн удирдах ажилтны нэгдсэн цахим зөвлөгөөн”-нийг Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын болон бүх шатны Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө, “Хүний Хөгжил-Эрүүл Мэндийг Дэмжих” урианы жилийн ажлын төлөвлөгөө болон бусад баримт бичгийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг болохуйц арга зүйн мэдээлэл зөвлөгөө мэдээлэл өгөх зорилгоор 27 сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, ИТХ-ын Нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга, Багийн Засаг дарга, Төсөвт Байгууллагын дарга эрхлэгч нарыг хамруулан 2021 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Коронавируст (Covid-19) цар тахлаас шалтгаалан аймгийн Удирдах ажилтны зөвлөгөөн анх удаа цахимаар зохион байгууллаа. Дунд хугацааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг эрчимжүүлэх, хяналт тавьж, үр дүнг тооцох чиглэлээр аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 22 Хэлтэс, агентлаг мэдээлэл өгч ажиллав. Мөн Зөвлөгөөний үеэр аймгийн Засаг дарга 27 сумын Засаг даргатай Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх, төсвийн орлого, зарлагын 2021 оны хуваарь бүхий 26 хэрэгжүүлэх арга хэмжээтэй гэрээ, батламжийг байгуулж, дэвшүүлсэн бодлого чиглэлийг тууштай, шуурхай, шударга, хариуцлагатайгаар хэрэгжүүлэн бүх шатанд анхаарч ажиллахыг Сумын Засаг дарга нарт үүрэг болголоо.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Цахим үндэстэн буюу E-Mongolia системийг хөдөөгийн хүн ам ихээр суурьшсан зарим багийн төвүүдэд нэвтрүүлж, Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Батсүмбэр сумын Үдлэгийн 4 дүгээр баг, Цогт-Өндөрийн 2 дугаар баг, Баянцогт сумын Гунын 1 дүгээр баг, Жаргалант сумын Баянбулагийн 3 дугаар баг, Загдалын 4 дүгээр баг, Заамар сумын Хайлаастын 3 дугаар багуудад төрийн үйлчилгээг операторын хэлбэрээр үзүүлэх иж бүрдэл тоног төхөөрөмжийг цахимаар хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулав.

Төрийн албаны тухай хуулийн дагуу удирдлагын академийн төрийн албаны мэргэшүүлэх багц болон дунд хугацааны сургалтад Төв аймгаас 14 албан хаагч хамрагдаж сургалтын төгсөлтийн сертификатыг гардуулав. Мөн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого /Алсын хараа 2050/ хөтөлбөрийн үзэл баримтлалын хүрээнд “Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ” сэдэвт богино хугацааны зайн сургалтад Хэлтэс, агентлаг, сумын ЗДТГ-ын дарга нарыг /нийт 29 албан хаагч/ хамруулж ажиллав. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Удирдлагын академи, мерит төслөөс хамтран зохион байгуулсан Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сургалтад хэлтсийн мэргэжилтнүүд хамрагдаж сертификатыг олгогдов.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/233 дугаар захирамжаар Төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөл, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчлан сэргийлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, зөв харилцаа хандлагыг төлөвшүүлэх шинэ санал санаачилгыг дэмжих замаар албан хаагчдын ёс суртахуунд эерэг нөлөө үзүүлэх зорилгоор нийт төрийн байгууллагуудын дунд "ЗӨВ ХАНДЛАГА-ЭЕРЭГ НӨЛӨӨ" нэг сарын аян зарласантай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газар дотоод албан хаагчдын дунд

-Ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулж, ажиллах журмыг батлан мөрдүүлэх.

-Төрийн албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн талаар байгууллага дотроо сэтгэл хангамжийн судалгаа авах

-Ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах.

-Ёс зүй, ёс суртахууны зөв хандлага төлөвшил, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн "Онч мэргэн үг" зохиох уралдаан

-Бусад байгууллагын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаатай танилцан туршлага судлах.

-Ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар богино хэмжээний видео зохиомж гаргаж, нийтэд хүргэх.

-БАЯРЛАЛАА карт солилцох арга хэмжээ зэрэг ажил арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажиллаж байна.

"Хөдөлмөрийн аюулгүй байдал-Эрүүл ахуйн сарын аян-2021" арга хэмжээг зохион байгуулах тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2021 оны 2/714, аймгийн Засаг даргын 2021 оны 01/489 дүгээр албан бичгийн дагуу манай байгууллага хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны удирдамж батлан хэрэгжүүлж, 2021 оны 4 дүгээр сарын 08-28-ны өдрүүдэд зохион байгуулж ажиллав. Тус аяны хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын Дотоод хяналтын зөвлөлтэй хамтран эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны хяналт шалгалтын ажлыг 2021 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулж, илтгэх хуудсаар холбогдох хэлтэс, албадад зөвлөмж чиглэл өгч түүний мөрөөр ажил сайжруулах төлөвлөгөө гарган ажиллаж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газраас хүсэлт тавьсаны дагуу ажилтан, албан хаагчдад зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх 2 удаагийн цахим сургалтад хамруулав.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/275 дугаар захирамжаар түүхт ой угтсан 100 бүтээлч ажлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, бэлтгэл ажил хангах чиг үүрэг бүхий зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг байгуулж, аймаг, сумын дунд хугацааны баримт бичиг, нөхцөл байдалтай уялдуулан түүхт ой угтсан 100 бүтээлч ажлын төлөвлөгөөнд тусгах тодорхой санал ирүүлэх тухай аймгийн ЗДТГ-ын даргын 2021 оны 02/639 дүгээр албан бичгээр хасвралт маягтын хамт аймгийн 27 сум, Хэлтэс, агентлагт хүргүүлж ажиллав.

Аймгийн Засаг даргын Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламж гэрээ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын аймгийн Засаг даргатай 2021 онд хамтран ажиллах гэрээ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарын нэгдсэн уулзалт, семинарын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр 27 болон холбогдох Хэлтэс, агентлагт хяналтын картаар хүргүүлж ажиллав.

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн ээлжит хуралдаан (7,8 дугаар) 2 удаа, ээлжит бус хуралдаан 1 удаа хуралдаж нийт 17 асуудал хэлэлцүүлэв. 2021 оны 4 дүгээр сарын 31-ны өдрийн байдлаар Монгол Улсын төрийн дээд одон медалиар шагнуулахаар үндсэн нэгж, сумын Засаг дарга, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс аймгийн Засаг даргад хандаж ирүүлсэн 170 иргэний тодорхойлолтыг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох яам, дээд шатны байгууллагад уламжлаад байна. Холбогдох яам, дээд шатны байгууллагаас дэмжсэн санал ирүүлсэн 77 иргэний материалыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж ажиллаа.

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэх, хүний хөгжил, сайн засаглал, нийгмийн салбар, үйлдвэрлэл үйлчилгээ, ажлын байр, төв суурин, дэд бүтэц, байгаль орчин зэрэг бүхий л салбарын хөгжлийг хангах төслүүдийг боловсруулах хэрэгжүүлэх, хяналт тавих, удирдлага зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий аймгийн орон тооны

бус “Хөгжлийн төслийн баг”-ийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор бүрэлдэхүүнийг шинэчлэн аймгийн Засаг даргын 2021 оны А/265 дугаар захирамжаар албажууллаа.

Уг төслийн багаас Эрүүл мэндийн яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хамтран өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн дунд зарласан “Эрүүл мэндийн тэгш байдлын манлайлагчид” төслийн уралдаанд оролцох сонирхол бүхий 17 сумын 80 гаруй сумдын хөгжлийн төслийн багийн гишүүн төрийн албан хаагчдад төслийн уралдаанд хэрхэн амжилттай төсөл бичиж оролцох талаар сургалт зохион байгуулж, уралдаанд оролцох төсөлд зөвлөгөө өгч одоогоор 2 төсөл уралдаанд оролцохоор байна.

Аймгийн онцгой комисст 800.000, хамтын ажиллагаат сум болох Эрдэнэсантад 200.000 хандив өгөв.

Мерит төсөлтэй хамтран аймгийн ЗДТГ-ын зарим хэлтэс, нэгжийг хамруулан “Хамтын ажиллагаа сайтай орчин бүрдүүлэх нь” сургалтыг зохион байгуулав.

2021 оны I улиралд иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ нэгтгэн ЗГХЭГ-т хүргэв. Уг мэдээнээс товч танилцуулбал:

Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны 7027-1111 дугаарт 15 санал, хүсэлт ирснээс 13-г шийдвэрлэж, 2 санал, хүсэлт хугацаа болоогүй шийдвэрлэх шатандаа байна. 7027-1111 дугаарт ирсэн санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8 хоног байна.

2021 оны I улиралд иргэдээс Төв аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал

/Өссөн дүнгээр/

№	Нэр	Нийт	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлтийн хувь
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1	Аймгийн ИТХ	9	8	1	0	0	100
2	Аймгийн ЗДТГ	80	68	1	0	11	86,25
3	Сумд	2431	2004	138	10	279	88,52
4	Харьяа агентлаг, хэлтэс	333	301	8	0	24	92,79
Нэгдсэн дүн		2853	2381	148	10	314	88,99

2021 оны I улиралд иргэдээс Төв аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдол хэлбэрээр

/Өссөн дүнгээр/

№	Нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол	Үүнээс				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар	Биечлэн уулзсан	Бусад
1	Аймгийн ИТХ	9	9	0	0	0	0
2	Аймгийн ЗДТГ	80	64	7	0	9	0
3	Сумд	2431	2317	22	5	67	20
4	Харьяа агентлаг, хэлтэс	333	304	27	2	0	0
Нэгдсэн дүн		2853	2694	56	7	76	20

2021 оны I улиралд иргэдээс Төв аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдол агуулгаар /Өссөн дүнгээр/

Төв аймаг	Нийт 2853 өргөдлөөс 1. Хүсэлт 2806/ 98.35% 2. Гомдол 34/ 1.19% 3. Санал 13/ 0.46% Газартай холбоотой асуудлаар 732 / 25,65% Хөл хорионы үед Улаанбаатар, хөдөө орон нутаг зорчих хүсэлт 365 /12,79% Иргэний бүртгэлийн чиглэлээр 356 / 12.47% Халамжийн үйлчилгээний чиглэлээр 330 / 11.56% Ажил, тусламж хүссэн 205 / 7.18%
-----------	---

Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхайг 2 удаа зохион байгуулж, хэрэгжилт тооцон ажиллалаа. Уг нэгдсэн шуурхайг цахимаар зохион байгуулж цар тахлын үед хүний бөөгнөрөл үүсгэх, эрсдэл үүсгэхгүй байхад анхаарч байна.

Төрийн албаны зөвлөлийн төв аймаг дахь салбар зөвлөлийн чиглэлээр:

1. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Төрийн албан хаагчийн 2020 оны улсын нэгдсэн тоо бүртгэлийн зарим өгөгдлийг ашиглан статистик тайлан гаргалаа. Төв аймгийн нутаг дэвсгэрт 199 төрийн байгууллага үйл ажиллагаа явуулж, 5560 албан хаагч ажиллаж, хөдөлмөрлөж байна. /Үүнд төрийн тусгай чиг үүрэгтэй зарим байгууллагын мэдээлэл ороогүй/.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН УЛСЫН НЭГДСЭН ТОО БҮРТГЭЛИЙН СТАТИСТИК (2020 оны жилийн эцэс, Төв аймаг)

Төрийн албан хаагчийн 2020 оны улсын нэгдсэн тоо бүртгэлийн дүнгээр Төв аймгийн нутаг дэвсгэрт 199 төрийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Үүнд төрийн тусгай чиг үүрэгтэй зарим байгууллагын мэдээлэл ороогүй/.


Эдгээр байгууллагуудад 5560 албан хаагч ажиллаж, төрийн албаны өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулж, ард иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байна.




Төрийн алба




2019 оны жилийн эцсийн статистик үзүүлэлттэй харьцуулахад төрийн байгууллагын тоо 19-өөр буурч, төрийн албан хаагчийн тоо 23-аар нэмэгдсэн байна.



Албан ту



Салбар зөвлөлийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссаны дагуу сум, орон нутгийн боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлэх, төрийн албаны сул орон тоог мэргэжлийн шаардлага хангасан орон нутгийн иргэдээс нөхөх боломжийг ахиулах зорилгоор “Их, дээд сургуульд суралцаж буй Төв аймгийн оюутан, залуусын судалгаа”-г 27 сумын Засаг даргын Тамгын газартай хамтран гаргаж, дүн шинжилгээ хийлээ. Энэхүү судалгаа нь анх удаа авагдсан бөгөөд мэргэжлийн




боловсон хүчний талаарх ерөнхий үзүүлэлтийг тодорхойлох боломж олгож байгаагаараа давуу талтай бөгөөд зарим үзүүлэлтээс танилцуулбал:

Судалгаанд нийт **1991** оюутан хамрагдсанаас эрэгтэй 807 буюу 40.53%, эмэгтэй 1184 буюу 59.46 байна. Дотоодын их, дээд сургуульд 1900 буюу 95.42% хувь нь, гадаад улсын их, дээд сургуульд 91 буюу 4.57% хувь нь суралцаж байна. Эдгээрийг курсээр ангилж үзвэл:



Мөн оюутнуудын эзэмшиж буй мэргэжлийг 18 бүлэгт ангилан курс тус бүрээр гаргасан.

Төв аймагт үүссэн коронавируст цар тахал, байгалийн гамшгийн нөхцөл байдлын улмаас орлогын тогтвортой эх үүсвэргүй суурин болон хөдөөгийн айл өрхүүд, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд эдийн засаг, нийгмийн болон сэтгэл зүйн олон хүндрэл бэрхшээл тулгарч байна. Иймд Төв аймаг дахь салбар зөвлөл, аймгийн ЗДТГ, “Төв HR” клубтэй хамтран гамшгийн нөхцөл байдлыг хохирол багатай даван туулахад ард иргэддээ дэмжлэг болох зорилгоор нийт төрийн байгууллага, албан хаагч нартаа хандан 4 арга хэмжээ бүхий уриалга гарган хүргүүлж хэрэгжилтийг 4 дүгээр сарын 30-ны байдлаар дүгнэлээ.



Уриалгын хүрээнд аймгийн Засаг даргын 2021 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн А/233 дугаар захирамжаар нийт төрийн байгууллагуудын дунд “ЗӨВ ХАНДЛАГА-ЭЭРЭГ НӨЛӨӨ” нэг сарын аян зарлалаа. Уг аяны зорилго нь төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөл, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчлан сэргийлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, зөв харилцаа хандлагыг төлөвшүүлэх шинэ санал санаачилгыг дэмжих замаар албан хаагчдын ёс суртахуунд эерэг нөлөө үзүүлэхэд чиглэж байна. Төрийн байгууллагууд аяны хүрээнд удирдамжийн дагуу 7 арга хэмжээг зохион байгуулж, үйл ажиллагааны тайлангаа 5 дугаар сарын 18-ны дотор ирүүлэх юм.

№	Төрлийн байгууллага	Хэрэгжилт
1	Төв аймаг	...
2	Төв аймаг	...
3	Төв аймаг	...
4	Төв аймаг	...
5	Төв аймаг	...
6	Төв аймаг	...
7	Төв аймаг	...
8	Төв аймаг	...
9	Төв аймаг	...
10	Төв аймаг	...
11	Төв аймаг	...
12	Төв аймаг	...
13	Төв аймаг	...
14	Төв аймаг	...
15	Төв аймаг	...
16	Төв аймаг	...
17	Төв аймаг	...
18	Төв аймаг	...

Уриалга, аяны хүрээнд ТАЗСЗ-өөс 20 байгууллагын 360 албан хаагчид “Төрийн албан хаагчийн ёс зүй” (анхаарах асуудал) сэдвээр танхимын болон цахим сургалт зохион байгууллаа.

Уриалгын 4 дэх арга хэмжээний хүрээнд 2021 оны 4 дүгээр сарын 01-ээс 29-ний өдрийн хооронд 51 төрийн байгууллага, албан хаагч нийт **17.598.080** төгрөгийн дэмжлэг, тусламжийг аймаг, сумын Онцгой комисст хүлээлгэн өгсөн байна. **Үүнд:**

- АОК-т 6.510.000 төгрөгийн мөнгөн тусламж, 4.000.000 төгрөгийн өртөг бүхий эд материал, хүнсний бүтээгдэхүүний дэмжлэг
- СОК-т 4.520.000 төгрөгийн мөнгөн тусламж, 2.568.080 төгрөгийн өртөг бүхий эд материал, хүнсний бүтээгдэхүүний дэмжлэг үзүүлжээ.



Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооноос Төрийн албаны хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тогтоох судалгааг 2021 оны 4 дүгээр сарын 05-наас 5 дугаар сарын 05-ны өдүүдэд цахим хэлбэрээр орон даяар зохион байгуулж байна. Уг судалгаанд Төв аймгийн 5376 албан хаагч хамрагдахаас 5167 буюу 96.11% нь хамрагдлаа.

Төрийн байгууллагуудын туслах чиг үүрэг бүхий албан хаагчдын ажил үүрэгт холбогдох аюулгүй ажиллагаа, үйлчилгээний стандартын талаарх мэдлэгийг ахиулж, цаг үеийн мэдээллээр

хангах зорилгоор “ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ НЬ” сэдвийн хүрээнд 4 төрлийн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж байна. Хэрэгжилтийн явцаас танилцуулбал:

Төрийн байгууллага, албан хаагч, ажилтны ажлын байрандаа болон албан томилолтоор ажиллах үед мөрдөх 6 төрлийн зааварчилгааг жишиг байдлаар боловсруулан ТАЗСЗ-ийн 2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 57 тоот албан бичгээр нийт байгууллагуудад хүргүүлээ. Мөн дээрх зааварчилгааг постер хэлбэрээр бэлтгэн цахим хуудсаар олон нийтэд танилцуулав. Үүнд:

- Төрийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангуулах ерөнхий зааварчилгаа (байгууллага, албан хаагч нарт-2 ш)
- Ажлын байрны орчинд баримтлах зааварчилгаа (ажилтан, албан хаагч нарт)
- Албан томилолтоор ажиллах үеийн зааварчилгаа (ажилтан, албан хаагч нарт)
- Жолоочийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- Жижүүрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- Үйлчлэгчийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа багтаж байна.



Тайлант хугацаанд төрийн алба, төрийн байгууллага, албан хаагчтай холбоотой дараах судалгаа мэдээллийг шинэчлэн гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлж, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын ажлын албаны 1992-2021 оны бүтэц, 2019-2021 оны аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгч, ажлын албаны орон тоо (2021.04.01)
2. 2020 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн үр дүнд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдсон боловч төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалд ажиллаж байгаа 5 иргэний судалгаа (2021.04.08)
3. Орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн тооцоот 6 үйлдвэрийн газрын бүтэц, орон тоо (2021.04.19)

2021 оны 4 дүгээр сарын байдлаар хариутай бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг танилцуулбал:

Төрөл	Нийт ирсэн	Үүнээс хариутай	Шийдвэрлэсэн эн	Хүлээгдэж буй	Шийдвэрлэлтийн хувь
Албан бичиг	113	58	52	6	89.65%
Өргөдөл, гомдол	9		6	3	66.67%

Салбар зөвлөлөөс 57 албан бичиг гадагш явуулснаас хариутай 41 бичиг байна. Үүнээс 38 буюу 92.68 хувь нь хугацаандаа шийдвэрлэгдэж, 3 нь хугацаа болоогүй хүлээгдэж байна.

2. Сургалт, мэдээллийн чиглэлээр:

Төрийн албаны зөвлөлөөс 4 дүгээр сард цахим хэлбэрээр зохион байгуулсан 9 удаагийн сургалтад салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд хамрагдлаа.

“Өлзий” ТВ, Төв аймгийн Хэвлэл мэдээллийн албаны 2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн “ТӨВ АЙМГИЙН ЦАГ” 30 минутын нэвтрүүлэгийг “Мэргэшсэн хариуцлагатай төрийн алба” зорилтын хүрээнд салбар зөвлөлөөс бэлтгэн олон нийтэд хүргэлээ.

<https://www.facebook.com/tovgov/videos/121790059939559>

2021 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулагдсан "Орон нутгийн удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөн-2021"-д салбар зөвлөлөөс “Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал” сэдвээр мэдээлэл өглөө. Уг зөвлөгөөнд 27 сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга, багийн Засаг дарга нар, төсөвт 4 байгууллагын дарга зэрэг 320 гаруй удирдах ажилтан оролцсон юм.

ЗГХЭГ-аас санаачлан хэрэгжүүлж буй “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ” сэдэвт 4 модуль бүхий цахим сургалтад салбар зөвлөлийн гишүүд амжилттай хамрагдаж, гэрчилгээ авлаа.

Канад улсын Мерит төсөл хэрэгжиж буй 4 аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, хүний нөөцийн мэргэжилтнүүдийн туршлага солилцох II уулзалтад оролцож, “Бүтээлч байдлын оюуны чадамж” сэдэвт сургалтад “Төв HR” клубын 5 гишүүнийг хамруулав.

“Төв HR” клубын 2 дахь уулзалт 4 дүгээр сарын 28-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулагдаж дараах асуудлуудыг хэлэлцлээ.

1. Нийгмийн даатгалын гар утасны аппликэйшний танилцуулга, хэрэглээ, давуу тал
2. Төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны талаарх санал бодол, анхаарах зүйл
3. Ирэх 5 дугаар сард хийх ажил болон 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг эрчимжүүлэх талаар санал солилцлоо.

3. Сонгон шалгаруулалтын чиглэлээр: Хойшилсон

Аймгийн нэгдсэн үйлчилгээ, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба-төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн хүрээнд:

2021 оны 04 дүгээр сард аймгийн Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд Төрийн болон бизнесийн дэмжих үйлчилгээний нийт **16** байгууллага **424** төрлийн үйлчилгээг **2551** иргэнд, өдөрт дунджаар **100-150** иргэнд хүргэж байна. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй ажил үйлчилгээ, арга хэмжээний мэдээллийг “Өлзий”, TBS, Төв, телевизүүдтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж иргэд олон нийтэд хүргэж байна. Мөн Аймгийн албан ёсны веб сайт болох www.tov.gov.mn, “Төв аймгийн хэвлэл мэдээллийн алба” нэртэй албан ёсны пейж хуудас, албаны мэдээллийн болон урсдаг самбар, ухаалаг дэлгэц зэрэг эх сурвалжаар иргэд, олон нийтэд түгээж байгаа бөгөөд энэ сард аймгийн веб сайт шинэчлэгдэн засварлагдаж байгаа учир сайтад мэдээ нийтлэгдээгүй, “Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба” пэйж хуудсанд **128** мэдээ мэдээлэл тус тус нийтлэгдлээ. Харин 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн **2** дугаарыг бэлтгэн иргэд олон нийтэд хүргэсэн бөгөөд бусад гэрээтэй телевизүүдийн мэдээний цагаар **26** мэдээ мэдээлэл давтагдсан тоогоор **60** гаруй удаа цацагдсан байна. Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд гомдол ирээгүй байна.

Мөн тус төв нь Засгийн газрын 149-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн мэдээлэл солилцооны E-mongolia цахим системийг нэвтрүүлж **16** байгууллагын **146** төрлийн лавлагаа мэдээллээр иргэдэд үйлчилж байгаа бөгөөд E-mongolia цахим системээр дамжуулан 04 сард аймгийн хэмжээнд **561** лавлагаа үйлчилгээг иргэдэд гарган өгч үйлчилсэн байгаагаас ТҮНТөвийн операторуудаас **102** лавлагаа үйлчилгээ авчээ.

Мэргэжлийн хяналтын чиглэлээр:

Мэргэжлийн хяналтын байгууллагын 2021 оны төлөвлөгөө, Өндөржүүлсэн бэлэн байдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Монгол улсын Засгийн газар, УОК-ын шийдвэр, МХЕГ-ын даргын 2020 оны А/146 дугаар тушаал, Аймгийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргын 2021 оны А/03, А/12, А/89, А/274 тоот захирамжууд, Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 19/03, 04, 06, 10, 11, 14, 20, 24, 25, 41, 56 тоот удирдамжуудын хүрээнд хяналт шалгалт хийгдэж байна.

Нэг. Төлөвлөгөөт хяналт шалгалт:

Коронавируст халдвар цар тахлын тархалт нэмэгдэж бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт буюу улаан түвшинд шилжсэнтэй холбоотой 2021 оны 04 дүгээр сард хийхээр төлөвлөгдсөн төлөвлөгөөт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ хийгдээгүй болно.

Зөвлөн туслах үйлчилгээ:

Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр Мэргэжлийн хяналтын байгууллагын 2021 оны нэгдсэн төлөвлөгөөний дагуу Төв аймгийн Зуунмод сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй РТА ХХК, Ундрам төв ХХК-д төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Урьдчилан сэргийлэх шалгалт:

Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын чиглэлээр МХЕГ-ын даргын баталсан Хууль бусаар ашигт малтмал олборлохоос урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд аймгийн БОАЖГ, ЦГ, ГХБХБГ-тай хамтран 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Сэргэлэн сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй “Үүрт гоулд” ХХК, “Газрын хүдэр” ХХК-иуд болон тухайн багийн нутагт цуглараад байгаа хууль бус гар аргаар ашигт малтмал олборлож буй иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж гүйцэтгэлээ. Шалгалтаар уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч тус 2 аж ахуйн нэгжид баримт бичгийг бүрдүүлэн мөрдөж, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах, КОВИД-19 цар тахлын үед халдвар хамгааллын дэглэмийг баримталж ажиллах талаар улсын байцаагчийн Зөвлөмжийг хүргүүлж ажилласан. Баримт бичгийн бүрдэл дутуу батлагдсан уулын ажлын төлөвлөгөөгүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй үйл ажиллагаа эхлүүлж байсан “Үүрт гоулд” ХХК-ийн үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар зөрчил арилгах хүртэл хугацаагаар зогсоов. Шөнийн цагаар Төв, Дархан-Уул аймаг, Багануур, Налайх, Багахангай дүүрэг гэх мэт газраас 100 орчим тээврийн хэрэгсэлтэй 300 гаруй иргэд цугларч шороо зөөвөрлөж буй үйл ажиллагааг таслан зогсоож 3 тээврийн хэрэгсэл 5 иргэнийг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлж ажилласан. Хууль бус гар аргаар ашигт малтмал олборлосон иргэдийн газрын хэвлийг хөндсөн газарт үзлэг, хэмжилт хийхэд 2000м², 7500м² хэмжээтэй 2 хэсэг газрын хөрсийг 10-15см зузаантайгаар хуулж авсан байна.

Хяналт шинжилгээ:

Тарих үрийн чанар, тариалалтын явцад урьдчилан сэргийлэх шалгалт хийх 19/23 дугаартай удирдамжийн хүрээнд 2021 онд тариалах үрийн шинжилгээг 11 сумын 68 аж ахуй нэгж, иргэний үр тарианы /улаанбуудай, арвай, овъёос/ 182 дээж, төмсний үрийн 151 дээжийг авч тарих үрийн чанар, ургамлын өвчин хортон шавжийн шинжилгээнд хамруулсан. Нийт 333 дээжийг 1260 үзүүлэлтээр шинжлэхэд одоогийн байдлаар 280 сорьц 1036 үзүүлэлтээр шинжилгээний хариу гарснаас 60 сорьцын 116 үзүүлэлт буюу 11,1% нь стандартын шаардлага хангахгүй үзүүлэлттэй байна. Стандартын шаардлага хангахгүй байгаа үзүүлэлт нь үр тарианы үрэнд 1кг дахь хог ургамлын үр, соёололт, цэвэршилт, чийг, төмсний үрэнд ургамлын өвчин, булцууны жин, хэлбэр хэмжээ голчын үзүүлэлт байна.

Үр тарианы үрийн соёололтын үзүүлэлт хүлээгдэж байна. Шинжилгээ үргэлжлэн хийгдэж байна.

Тандалт судалгаа:

МХГ-ын даргын баталсан 19/42 дугаартай удирдамжийн хүрээнд Боловсролын байгууллагын ус, ариун цэврийн байгууламжийн эрүүл ахуйн норм, дүрэм, стандартын хэрэгжилтийн байдалд хийх тандалт судалгаанд 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар 16 цэцэрлэг, 14 сургуулийг хамруулаад байна.

Баталгаажуулах үйл ажиллагаа:

Барилгын техникийн хяналтын чиглэлээр:

1. Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан “Баталгаажуулалтын шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын Соёлын төвийн барилга, Улаанбаатар төмөр замын Улаанбаатар өртөөний “Мааньт” өртөөний вагон засварын ажилтны байр болон тос агуулах барилга, Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газрын болон Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны барилгуудын Байгалийн гамшигт үзэгдлийн дараах төлөв байдалд тус тус

хяналт шалгалт хийж, улсын байцаагчийн ашиглалтын төлөв байдлын тухай 3 дүгнэлт, ашиглалтыг зогсоох тухай 2 акт үйлдэж, биелэлтийг хангуулж ажилласан.

2. Монгол улсын Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын дагуу аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн мэдэгдлийн дагуу Бүрэн, Баянхангай сумдын төвд баригдсан Мэдээлэл, холбоо сүлжээ ТӨХХК-ийн Холбооны техникийн байрны барилгууд, ХААН банкны Тооцооны төвийн барилгуудын ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнд тус тус ажилласан.

Салбарын сургалт: Хөдөлмөр, Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2020 оны А/131 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт шалгалтын төлөвлөгөө болон тус газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төв аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, барилгын салбарын аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан 30 ажилтанд ХАБЭА-н ажилтнуудад үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх, ажилтнуудын эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад чиглэгдсэн салбарын сургалтыг 2021.04.26-нд цахимаар зохион байгуулсан.

Хоёр. Төлөвлөгөөт бус шалгалт:

1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр ирүүлсэн 03/763 тоот албан бичгийн дагуу Монгол эм импекс ХХК-ийн Төв аймгийн салбар болон тус салбараас зарим сумын эргэлтийн эмийн санд түгээгдсэн эмийг эргүүлэн татах ажилд хяналт тавьж, тайлан мэдээг хүргүүлэв.

2. МХГ-ын даргын баталсан 2021 оны 19/41 дугаар удирдамжийн хүрээнд Аймгийн Эрүүл мэндийн газрын үйл ажиллагаатай холбоотой иргэнээс ирүүлсэн өргөдлийн хүрээнд Эм био бэлдмэл, Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчид төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж тус газарт илэрсэн зөрчлийг арилгуулахаар 8 заалттай 1 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, иргэнд хяналт шалгалт хийсэн тухай илтгэх хуудас хүргүүлж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

3. Газрын даргын баталсан 2021 оны 19/56 дугаартай удирдамжийн хүрээнд Аймгийн нэгдсэн эмнэлгийн эмгэг судлалын хэсэгт төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

4. Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 19/54 дүгээр удирдамжийн хүрээнд төв болон урьдчилан цэвэрлэх байгууламжид төлөвлөгөөт бус шалгалт хийж байна. Шалгалтын явцад цэвэрлэх байгууламжийн оролт, гаралтын хэсгээс хими, нян судлалын шинжилгээнд дээж авч шинжилгээнд хамруулсан бөгөөд шинжилгээний хариу гараагүй байна.

5. Сэргэлэн сумын 4-р зөрлөг, Өндөр дов зэрэг авто тээврийн шалган нэвтрүүлэх постод ажиллаж буй “Ковид-19” халдварын ПГУ, түргэвчилсэн шинжилгээ авах түр цэгт төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Илэрсэн зөрчилгүй.

6. Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр иргэнээс ирүүлсэн өргөдөл, Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 2021 оны 03 дугаар сарын 31-ний 19/36 дугаар удирдамжийн дагуу Төв аймгийн Биеийн тамир, спортын газарт төлөвлөгөөт бус шалгалт хийж тухайн иргэний төлөгдөөгүй нийгмийн даатгалын шимтгэл, алданги нөхөн төлүүлэх тухай улсын байцаагчийн 19-06-035/37 дугаартай акт тогтоосон.

7. Геологи уул уурхайн хяналтын чиглэлээр Төв аймгийн Заамар сумын сум дундын Цагдаагийн хэлтэсээс 2021 оны 44/06-67 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж Төв аймгийн Заамар сумын нутаг Бэрх-Уул гэх газарт үйл ажиллагаа явуулдаг “Тин Хун” ХХК-ийн ажилтанд Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдсон гэх үндэслэлээр 50 нэгжтэй тэнцэх хэмжээний торгуулийн арга хэмжээ авсан.

8. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 09/718 тоот бичгээр ирүүлсэн Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт үйл ажиллагаа эрхлэгч иргэн С.Рэгзэдмаагийн өргөдөл гомдлын дагуу 2021 оны 04-р сарын 05-ны өдөр “Пирамид Прогресс” ХХК-

д хяналт шалгалт хийж 1000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.

Гурав. Төв аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/03, А/12, А/122, А/215, А/274 тоот өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн арга хэмжээний тухай захирамжийн дагуу “Хүнсний худалдаа үйлдвэр, хадгалалт, түгээлтийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх”

Аймгийн Засаг даргын А/215, 274 тоот захирамжийн дагуу зах худалдааны төв, хүнсний дэлгүүрүүдийн цагийн хуваарийг 10:00-19:00 цагийн хязгаарлалт тогтоон ажиллаж байна. МУЗГ-ын 45 дугаар тогтоол, УОК-ын даргын баталсан “Түр журам батлах тухай” 18 дугаар тушаал, МХЕГ-ын даргын баталсан 01/48 тоот удирдамжийн хүрээнд халдвар хамгааллын дэглэмийн байдалд тусгай нөхцөл шаардлагыг нийтийн үйлчилгээ сургалт хүнсний үйлдвэрлэл худалдаа үйлчилгээний байгууллагад давхардсан тоогоор 592 хяналт шалгалт хийж 377 зөрчил илрүүлж 198 зөрчлийг газар дээр нь арилгуулж тусгай нөхцөл шаардлагыг хангасан 83 хүнсний дэлгүүр, 4 банк, хүнсний үйлдвэрлэлийн 4 цехэд эрүүл ахуй халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтөд өдөр бүр графикийн дагуу тогтмол хяналт тавин ажиллаж байна. Хяналт шалгалтын явцад хадгалалтын хугацаа дууссан 102 нэр төрлийн 381 ширхэг 879000 төгрөгийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг хураан авч Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлэн ажилласан.

Дөрөв: Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоо Сэргэлэн сумын 4-р зөрлөг, Өндөр довын хяналтын постуудад нийт улсын байцаагчид батлагдсан хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэж зөрчилтэй тээврийн хэрэгсэл, зорчигчийг буцааж МХГ-ын Шуурхай штабын хариуцлагатай жижүүрт тухай бүр нь мэдээлэн ажиллаж байна.

Тав: Улсын онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 18 тоот тушаалаар батлагдсан “Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх түр журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэм сахиулах, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бүрдүүлэх зорилгоор:

МУЗГ-ын 2021 оны 45, 105 дугаар тогтоол, УОК-ын даргын “Түр журам батлах тухай” 2021 оны 18 дугаар тушаал, МХЕГ-ын даргын баталсан 01/48 дугаар удирдамжийн хүрээнд нийтийн үйлчилгээ сургалт хүнсний үйлдвэрлэл худалдаа үйлчилгээний байгууллагад давхардсан тоогоор 1276 хяналт шалгалт хийж 1710 зөрчил илрүүлж 540 зөрчлийг газар дээр нь арилгуулж мэргэжлийн байгууллагын тусгай нөхцөл шаардлагыг хангасан 63 хүнсний дэлгүүр, 4 банк, харилцаа холбоо мэдээллийн 3 байгууллага, нэгжид эрүүл ахуй халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтөд өдөр бүр хяналт тавин ажиллаж байна. Хяналт шалгалтаар үйлчлүүлэгч, ажилчдын биеийн халууныг хэмжээгүй, бүртгэл хөтлөөгүй 8.7%, зай барих тэмдэг, тэмдэглэгээ байршуулаагүй, үйлчлүүлэгч хооронд зай барих талаар шаардлага тавиагүй 8.3%, түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалтын горим, ажилчдын халдвар хамгааллын хувцас ариутгалын бодисын нөөц бүрдүүлээгүй 25.8%, сэжигтэй тохиолдлын түр тусгаарлах байр шаардлага хангасан байр бэлдээгүй 17.9%, хүний бөөгнөрөл үүсгэхгүй урьдчилан захиалга авч үйлчлэх нөхцөл бүрдүүлээгүй 6.8%, ахуйн хог хаягдалыг ангилан цуглуулж байгууллагын гаднах 50 м орчимд цэвэрлэгээ үйлчилгээ хийгээгүй 6%, шууд хэрэглэх хүнсний бүтээгдэхүүнийг ил задгай худалдаалсан 5.8%, гар угаах, халдваргүйжүүлэх нөхцөл бүрдүүлээгүй 11%, QR код байршуулаагүй 7.9 % байна. Хяналт шалгалтын явцад хадгалалтын хугацаа дууссан 165 нэр төрлийн 797 ширхэг 1699575 төгрөгийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг хураан авч Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн.

Зургаа: Тусгаарлан ажиглах байрны эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийн хэрэгжилт:

Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх түр журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Зуунмод, Батсүмбэр, Алтанбулаг сумдад 04 дүгээр сард коронавируст халдвар Ковид -19 өвчин батлагдсан 21 өрх, 14 байгууллага, аж ахуйн нэгжийн нийт 9401м² талбайд голомтын эцсийн халдваргүйтгэл хийхэд хяналт тавьж ажилласан.

Долоо. Дархлаажуулалт:

1. Аймгийн Онцгой комиссын дарга буюу аймгийн Засаг даргын 2021 оны 03 сарын 26-ны өдрийн А/213 дугаар захирамжийн хүрээнд 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр ХӨСҮТ-өөс коронавирусын эсрэг 0,5 мг-ийн фалконтой БНХАУ-ын Синофарм компанид үйлдвэрлэгдсэн 6901 хүн тун Вероцелл вакцины тээвэрлэлт хадгалалт хамгаалалтад Эм био бэлдмэл, Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчид хяналт тавьж ЭМГ-ын ЗХӨТСТ-ийн дэргэдэх дархлаажуулалтын нөөц хадгалах өрөөнд аюулгүй байршуулсан.

2. Коронавируст халдварын эсрэг вакциныг сумдад хүргэх Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан 3 ажлын хэсэгт Эмчилгээ, Эм био бэлдмэл, Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчид ажиллан вакциныг тээвэрлэх, хадгалалт, чанар аюулгүй байдалд хяналт тавин 25 суманд 4362 хүн тун вакциныг +3 оос +7 хэмд аюулгүй зөөвөрлөж сумдын эрүүл мэндийн төвд хүлээлгэн өгч, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажилласан.

Найм. Сорилтын нэгдсэн лаборатори:

1. Итгэмжлэгдсэн лаборатори нь өнгөрсөн 1 сарын хугацаанд 209 сорьцыг шалгаж хүлээн авч 734 үзүүлэлтээр сорилыг гүйцэтгэн үр дүнг баталгаажуулан шинжилгээний хариуг хугацаа хэтрүүлэхгүй олгосон байна. Үүнээс нян судлалын шинжилгээгээр 16 сорьц 16, химийн шинжилгээгээр 2 сорьц 2, тарих үрийн чанар, хорио цээрийн шинжилгээгээр 32 сорьц 58 үзүүлэлтээр буюу нийт 40 сорьц 76 үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй дүнтэй гарсан байна.

Мөн тус лабораторид ISO 17025-ын 8.4, “Бүртгэлийн хяналтын журам. ХИЛНС.8.4” болон Эрсдэл ба боломжийг шийдвэрлэх менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дотоод хяналтыг лабораторийн эрхлэгч 2021 оны 04 дүгээр сарын 16-21-нд хийж гүйцэтгэлээ. Дотоод хяналтад нийт 28 бүртгэл, техник ашиглалтын 58 паспорт, шалгалт тохируулгын хуудас 28 нийт 114 бүртгэл, сорилтын нэгдсэн лабораторийн 6 цэгээс агаарын дээж авч 12 /нянгийн тоо, хөгц мөөгөнцөр/, арчдасны 40 сорьц авч 40 үзүүлэлтээр /ГБСавханцар/, ариутгасан 7 шил савны ариун чанарт хяналт тавьж, нийт 53 сорьцыг 59 үзүүлэлтээр тус тус хяналтад хамрагдлаа. Хяналтаар бүртгэлийн 9, орчны 7 нийт 16 үл тохирлыг илрүүлж залруулах ажиллагааг явуулсан.

Ес. Бусад ажлууд:

1. Аймгийн нэгдсэн эмнэлэг, 26 сумын эрүүл мэндийн төвөөс эмнэлгийн гаралтай хог хаягдлын мэдээг 2021.04.13-ны өдрөөс эхлэн өдөр бүр авч нэгтгэн МХЕГ-ын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч Д.Батдуламд ddulma3923@yahoo.com хаягаар хүргүүлж байна.

2. “Тариалалтын зөвөлгөөн-2021” аймгийн зөвөлгөөн цахимаар зохион байгуулагдаж 27 сумын 150 гаруй газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуй нэгж, иргэд оролцож хаврын тариалалтын бэлтгэл ажлын хүрээнд тарих үрийн чанар, стандарт, ургамал хамгаалах химийн бодисны зохистой хэрэглээ, ургамлын гарал үүслийн цахим систем, бэлчээрийн болон тариалангийн талбайн үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээ, сүүлийн жилүүдэд газар тариалангийн хяналтын чиглэлээр хийгдсэн ажил, зөрчил дутагдал, цаашид авах арга хэмжээ болон анхаарах асуудлаар мэдээ мэдээлэл хүргэж ажиллалаа.

3. БНХАУ-аас зохион байгуулсан Ковид-19-н эмчилгээ оношилгоо, вакцины чиглэлээр эмчилгээ, эм био бэлдмэлийн байцаагчид онлайн сургалтад Voov app-г холбогдож 7 хоног оролцсон.

4. “Үр дүнд суурилсан хяналт, шинжилгээ, үнэлгээ” цогц сургалтад тус газрын 20 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авсан.

5. Эм эмнэлгийн хэрэгслийн бүтээгдэхүүний тухай шинэчилсэн хуулийн төсөлд санал хүргүүлсэн.

6. МХЕГ-ын ДБХГ-аас ирүүлсэн шинэчлэн боловсруулах “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм” болон “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-д санал хүргүүлсэн.

7. “Зөв хандлага-Эерэг нөлөө” сарын аяны хүрээнд “Төрийн албан хаагчийн ёс зүй, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” онлайн сургалтад тус газрын 26 албан хаагч хамрагдсан.

8. МХЕГ-ын 2021.04.20-ны өдрийн 02/910 тоот үүрэг даалгавар хүргүүлэх тухай албан бичгийн дагуу Төв аймгийн хэмжээнд уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдээс судалгаа авч МХЕГ-т хүргүүлсэн.

9. Газрын даргын тушаалаар батлагдсан хуваарийн дагуу /ковид-19/ халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хүрээнд автотээврийн шалган нэвтрүүлэх цэг, худалдаа үйлчилгээний газрууд, ариутгал халдваргүйтгэлийн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт хийж, байгууллагын байнгын ажиллагаатай шуурхай штабд хариуцлагатай жижүүрийн үүргийг 24 цагаар гүйцэтгэн, мэдээ мэдээллийг МХЕГ-ын болон аймгийн Шуурхай штабт тогтоосон хугацаанд тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.

Онцгой байдлын газрын хүрээнд:

№	Огноо	Мэдээ өгсөн хүний нэр, утасны дугаар	Мэдээний агуулга /Байршил/	Хүн хүч техник хэрэгсэл	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
	Цаг минут				
Гамшиг ослын бүртгэл					
1	2021.04.19 08:00	Тус сумын БОУХБайцаагч Ш.Гэрэлт-од	Эрдэнэ сумын Чулуут 2-р багийн Булнаа гэдэг газар сумын төвөөс зүүн хойд зүгт 133км М.Цэндсүрэн 15 настай эрэгтэй хүүхэд 2021.04.18ны өглөө 08:00 цагаас хойш малдаа яваад сураггүй болсон тухай дуудлага хүлээн авсан.	ГТУХБ а/д Д.Бадамсамбууга ар ахлуулсан 7 алба хаагч, 1 автомашин, 1 эрэлч нохой, Ш.Гэрэлт-одоор ахлуулсан 5 алба хаагч, 1автомашинтай ар гэрээс 10 хүн 5 мотоциколь ажилласан	М.Цэндсүрэн /15 настай, эрэгтэй/ гэрээс баруун хойд зүгт 800 метрт модноос дүүжлэгдэн нас барсан байсныг олсон
Хөдөө орон нутгийн /Объектын галын бүртгэл/					
1	2021.04.02 03:50 цагт	иргэн Д.Энхбаяр /99003289/	Төв аймгийн Мөнгөнморьт сумын Жаргалант багийн “Аргалагийн ам” гэдэг газарт /сумын төвөөс баруун хойд зүгт 180 км-т, Аймгийн төвөөс зүүн хойд зүгт 374 км-т/ 2021.03.31-ны 03:50 цагт /Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны “Булагчны” 5 дугаар гудамжны 121 тоотод оршин суугч иргэн Г.Ганбагана /45 настай, эмэгтэй/ самарт гэр бүлийн 2 гишүүнтэй Нөхөр Х.Төмөр-Очир /42 настай, эрэгтэй/, Охин Г.Солонго, /21 настай эмэгтэй/ явж байгаад шатаж нас барсан тухай	Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч ахмад Г.Отгонбаатар, Аймгийн цагдаагийн газрын дэд дарга цагдаагийн хошууч Г.Жанчиваар ахлуулсан 8 алба хаагч, Мөнгөнморьт сум дахь хэсгийн төлөөлөгч цагдаагийн дэслэгч Л.Ган-Эрдэнэ нийт 10 алба хаагч /УАЗ Фургон 01-08 ТӨА	Тухайн иргэн самарт гэр бүлийн 2 гишүүнтэй Нөхөр Х.Төмөр-Очир /42 настай, эрэгтэй/, Охин Г.Солонго, /21 настай эмэгтэй/ нартай хамт явсан

			дуудлагыг хүлээн авсан.	улсын дугаартай/ 2 автомашинтай ажилласан	
2	2021.04.23 03:42 цагт	Иргэн Э.Ариунаа /91452585/	Төв аймгийн Батсүмбэр сумын Үдлэг багийн нутаг "Нарстай ам" гэдэг газарт /сумын төвөөс баруун урд зүгт 15 км-т, Аймгийн төвөөс хойд зүгт 86 км-т/ иргэн Э.Ариунаагийн 10х7 эзэмшлийн малын хэмжээтэй өвөлжөө 12 үхрийн хамт бүрэн шатсан. бүрэн шатсан тухай дуудлагыг хүлээн авсан.	Тус аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 75 дугаар ангийн 3 алба хаагч, 1 автомашинтай 15 километр замыг туулан 04:24 цагт голомтод хүрэлцэн очиж 06:09 цагт ангийн байрлалд ирсэн	Уг гал түймэрт бэртэж гэмтсэн хүн байхгүй. Бүрэн шатсан.
3	2021.04.24 09:59 цагт		Сэргэлэн сумын Эрдэнэ уул багийн Уяагдын холбоо гэдэг газарт өвө шатаж байна гэсэн дуудлага хүлээн авсан.	Төв аймгийн ОБГ-ын ГТУХБ-гч а/д Д.Бадамсамбууга ар ахлуулсан ГТУА 24-р ангийн 4 алба хаагч, 1 автомашинтай	
4	2021.04.24 14:00 цагт	Тус сумын Засаг даргын Тамгын газрын дарга Н.Ширнэн /99207176/	Аргалант сумын Аргалын-Уул багийн "Хар чулуут" гэдэг газарт /сумын төвөөс урд зүгт 4 км-т, аймгийн төвөөс баруун хойд зүгт 135 км-т/ өвөлжөө шатаж байна гэсэн мэдээллийг хүлээн авсан.	Тус сумын Засаг даргын Тамгын газрын 12 албан хаагч, 3 автомашинтай 14:10 цагт очиход иргэн Ц.Цогнэмэхийн 24х6 хэмжээтэй өвөлжөөний дээвэр болон ар талын хэсэг шатаж байсныг 15:55 цагт унтраасан гэсэн мэдээг тус сумын Засаг даргын Тамгын газрын дарга Н.Ширнэн /99207176/ мэдэгдсэн.	Дээвэр болон ар талын хэсэг шатсан.
5	2021.04.24 09:59 цагт	Тус сумын Засаг даргын тамгын газрын дарга Б.Мөнхцэцэг /89059867/	Сэргэлэн сумын Эрдэнэ-Уул багийн Уяачдын хороолол /Сумын төвдөө/ өвс шатаж байна гэсэн дуудлагыг хүлээн авсан.	Тус аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 24 дүгээр 5 алба хаагч, 1 автомашинтай 15 км зам туулан 11:05 цагт дуудлагын газар очиход иргэн Д.Бадрахын 2	Нийт 600 боодол буюу 15 тонн өвс бүрэн шатсан.

				нуруу өвсний 1 нуруу нь шатаж дуусаад 2 дох нуруу нь шатаж эхэлж байсныг 2 цаг ажиллаж 16 тонн ус зарцуулж унтраасан.	
6	2021.04.28 04:15 цагт	иргэн А.Нурсэрэк /80543313/	Сэргэлэн сумын Баянбүрд багийн нутаг "Цэцүүх трейд ХХК"-ний хуванцарын үйлдвэр /Аймгийн төвөөс зүүн зүгт 24 км-т, сумын төвөөс зүүн хойд зүгт 22 км-т/ "Цэцүүх трейд ХХК"-ний эзэмшлийн хашаанд их хэмжээний шуудай шатаж байна гэсэн дуудлагыг дуудлагыг хүлээн авсан	Тус аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 24 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч Т.Төмөрбаатар р ахлуулсан 5 алба хаагч, 1 автомашинтай, нэмэлтээр 05:35 цагт 2 алба хаагч, 1 автомашинтай хүрэлцэн очиход шороо болон шохойтой холилдсон шуудай шатаж байсныг 4.5 тонн ус зарцуулж 1 цаг 23 минут ажиллаж унтраасан.	Бүрэн унтраасан.
Ой хээрийн түймрийн бүртгэл					
1	2021.04.08	Г.Энхболд /70112111/	Төв аймгийн Эрдэнэ сумын Чулуут багийн "Хойдхын гацаа" гэдэг газарт /сумын төвөөс хойд зүгт 75 км-т, Аймгийн төвөөс зүүн зүгт 158 км-т/ ой хээрийн түймэр гарсан тухай дуудлагыг 2021.04.08-ны өдрийн 13:55 цагт хүлээн авсан.	Тус сумын Засаг дарга А.Мөнгөнбаяраар ахлуулсан 11 хүн, 1 автомашин, 7 морьтой ажиллаж байна. Нийт 30 га талбай өртсөн 1 талаас нь хумиад унтрааж байна. 23:08 цагт цурманд оруулсан..	

Гурав. Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд:

Удирдлага зохион байгуулалтын хүрээнд:

Хууль зүйн салбарын хүрээнд 27 сумын удирдлагуудад 2021 онд анхаарах асуудлаар сургалт явуулж, Төв аймаг дахь Цагдаагийн газар, Тагнуулын хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас чиглэл өгч ажиллалаа. Сургалтын үеэр Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутаг төлөөлөн хэрэгжүүлэх талаар аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний хавсралтад 7 чиглэлийг тусган сумдад албажуулан хүргүүлээ.

ХЗДХЯ, ХЗС-тай хамтран Зууны мэдээ сонины 7 хоног тутмын –“Хуульч зөвлөж байна” асуулт хариултын булан, Монголын радиогийн сар тутмын “Хуулийн цаг” зохиомжит нэвтрүүлгийн 04 сарын дугааруудыг бэлтгэн радио телевизээр дамжуулан хүргэлээ.

Аймаг, сум, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын 48 шийдвэр, гэрээний төслийн хууль зүйн үндэслэлийг хянаж, эрх зүйн асуудлаар 52 иргэн болон сум, байгууллагуудад хууль зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанаас 2021 оны 5/125 тоот “Үндэсний аюулгүй байдлыг хангах тухай” 19 заалт бүхий чиглэл ирүүлснийг 27 сум, 26 байгууллагад хүргүүлж, хяналтад авхууллаа.

“Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан Төв аймгийн хэмжээнд “Хуванцар бохирдолтой тэмцэх” 14 хоногийн аяныг 27 сумын 381 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй эрхлэгчдийг хамруулан зохион байгуулж, хүүхэд залуучуудын дунд “Хуванцар бохирдолтой тэмцэхэд бидний оролцоо” сэдэвт цахим зохион бичлэгийн уралдааныг явуулж 14 сумын Ерөнхий боловсролын сургуулийн 154 хүүхэд оролцоноос 28 хүүхдийг шалгаруулан шагнаж, урамшууллаа.

Аймгийн засаг даргын баталсан удирдамжийн дагуу Зуунмод суманд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, согтууруулах ундааны зүйл худалдан борлуулж буй эсэхэд хяналт шалгалт явуулах “Ажлын хэсэг” томилон хүнсний дэлгүүр, зах худалдааны 48 цэгт 3 удаагийн хяналт шалгалт явуулж, 13 зөрчил дутагдал илэрснийг бүрэн арилгуулж, бараа бүтээгдэхүүний үнийн хөөрөгдлөөс урьдчилан сэргийлэх “Мэдэгдэл” өгч ажиллалаа.

Архивын тасгийн чиглэлээр:

Төрийн архивын эх баримтаас 117 иргэний хүсэлтийг хүлээн авч 617 хуулбар хувь ,60 лавлагаа, 138 хөмрөгийн 578 хадгаламжийн нэгжийн баримтыг ашиглан лавлагаа мэдээллээр үйлчилгээ үзүүлээ.

2 хөмрөгийн 74 хадгаламжийн нэгжийн 3936 хуудас баримтын 16983 хүний нэр, 3759 заалтын тоо, 3759 тушаалын тоог мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, 2 хөмрөгийн 74 хадгаламжийн нэгжийн 3963 хуудас баримт скайнердаж, 2 хөмрөгийн 74 хадгаламжийн нэгжийн 3759 заалтыг PDF.JPEG хэлбэрт хувиргаж, 3759 заалтын 3936 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбож цахим бааз үүсгэлээ. Орон нутгийн төсөвт 149.0 төгрөгийг орууллаа.

Улсын бүртгэлийн чиглэлээр:

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр цахим санд нийт 58680 хувийн хэрэг байгаагаас Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 10619, Газар өмчлөх эрхийн 48061 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 27365.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос 66.0 сая төгрөгийг улсын төсөвт орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 140 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 92 нэмэлт өөрчлөлт, шинээр 48 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 0, үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 18, эцсийн өмчлөгч 16 бүртгэл хийгдлээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 10 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 7 лавлагаа өгч, орон нутгийн 5.7 сая төгрөгийг орууллаа.

Цагдаагийн газрын үйл ажиллагааны чиглэлээр:

Аймгийн хэмжээнд нийт 177 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 122 хэргээр буюу 40,8 хувиар буурсан. Гэмт хэргийн илрүүлэлт 31,8 хувьтай, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,9 хувиар буурсан.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Хөл хорионы үед явган эргүүлийн 98 чиглэлд Онцгой байдлын 29, цагдаагийн 99, бусад байгууллагаас 200 алба хаагч, Зэвсэгт хүчний 016 дугаар бригадаас 24 алба хаагч, Шүүхийн шинжилгээний албанаас 16 албан хаагч үүрэг гүйцэтгэх хугацаанд батлагдаагүй зам маршрутаар явсан 79 зөрчлийг илрүүлж 27 иргэнийг 13.5 сая төгрөгөөр торгосон.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон 39 жолоочийг илрүүлж, 38 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодон хөдөлгөөнд оролцсон 1 иргэнийг сум дундын хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлууллаа. Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 735 жолоочийг 44.0 сая төгрөгийн торгууль оногдуулж, 31 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатуулан, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллалаа.

Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааны чиглэлээр:

Энэ сард Криминалистикийн шинжилгээ-71, нийт хийсэн магадлан шинжилгээ-35, хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-189, гарын хээний санг баяжуулсан-72, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн дүгнэлт 188 гаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны чиглэлээр:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
04 дүгээр сар	245	100	19	326	86	240	26.4%
	4622247.6	820273.1	626573.0	4815947.7	553997.3	4261950.4	

Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд:

Аймгийн хэмжээнд 2021 онд **56 941,0 сая** төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэхээр төлөвлөгдлөө.

Үүнд:

- **Улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжих 42351.9 сая төгрөгийн** санхүүжилтээр 37 төсөл, арга хэмжээ тусгагдсанаас 2020 онд хэрэгжиж эхэлсэн 20 төсөл арга хэмжээ, эрх шилжиж ирсэн 12 төсөл, арга хэмжээ, эрх шилжиж ирээгүй 5 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс 11 ажилд худалдан авах ажиллагаа зарлаж 2 ажил / Сумын төвийн авто зам 3,2км /Төв, Эрдэнэсант сум/ -төсөвт өртөг 1,081,300,000 төгрөг, Нээлтийг 2021.04.26-нд, Зуунмод сумын төвөөс Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн авто зам /Төв, Зуунмод сум/-төсөвт өртөг 8,161,700,000 төгрөг, Нээлтийг 2021.04.26-нд тус тус зохион байгуулж үнэлгээний шатанд байна. Дараах 9 ажлын худалдан авах ажиллагааг зарлан тендерийн нээлтийг хүлээж байна. Үүнд:
 1. Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Төв, Архуст сум/ -төсөвт өртөг 400,000,000 төгрөг, Нээлтийг 2021.04.30-нд;
 2. Цэцэрлэгийн барилга /Төв, Угтаалцайдам сум/ -төсөвт өртөг 1,300,000,000 төгрөг, Нээлтийг 2021.05.19-нд;
 3. Цэцэрлэгийн барилга /Төв, Лүн сум/ -төсөвт өртөг 1,500,000,000 төгрөг, Нээлтийг 2021.05.19-нд;
 4. Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Төв, Баянжаргалан сум/ -төсөвт өртөг 800,000,000 төгрөг, Нээлтийг 2021.05.17-нд;
 5. Сургуулийн барилгын дээврийн их засвар /Төв, Баянчандмань сум/ -төсөвт өртөг 180,000,000 төгрөг, Нээлтийг 2021.04.30-нд;
 6. Хичээлийн А байрын барилгын их засвар /Төв, Зуунмод сум, Хүмүүн цогцолбор сургууль/ -төсөвт өртөг 733,600,000 төгрөг, Нээлтийг 2021.05.14-нд;
 7. Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар /Төв, Аргалант сум/ -төсөвт өртөг 729,200,000 төгрөг, Нээлтийг 2021.04.29-нд;

8. Сургуулийн барилгын дээврийн их засвар /Төв, Баян-Өнжүүл сум/ -төсөвт өртөг 50,000,000 төгрөг, Нээлтийг 2021.04.30-нд;
 9. Эмнэлгийн барилга 15 ор, /Төв, Баянцогт сум/ -төсөвт өртөг 1,700,000,000 төгрөг, Нээлтийг 2021.04.30-нд тус тус хийнэ.
- **Орон нутгийн хөгжлийн сангаар 6357.8 сая төгрөгийн** 43 төсөл, арга хэмжээ хэрэгжихээс 23 төсөл, арга хэмжээ Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 12 төсөл арга хэмжээ харьцуулалтын аргаар нийт 35 төсөл арга хэмжээ тендер зарлахаар төлөвлөсөн. Үүнээс 17 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зарлаж 3 төсөл арга хэмжээнд гүйцэтгэгч шалгарч 1 төсөл арга хэмжээг дахин зарлахаар болж 2 төсөл арга хэмжээнд үнэлгээ хийх шатанд 11 төсөл арга хэмжээний тендерийн нээлтийг хүлээж байна.
 - **Аймгийн төсвийн шилжих үлдэгдлээр 3500.0 сая төгрөгийн** 13 төсөл, арга хэмжээ хэрэгжихээс 6 төсөл, арга хэмжээ Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 2 төсөл арга хэмжээ харьцуулалтын аргаар нийт 8 төсөл арга хэмжээ тендер зарлахаар төлөвлөсөн. Үүнээс 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зарлаж 1 төсөл арга хэмжээнд гүйцэтгэгч шалгарч 1 төсөл арга хэмжээний тендерийн нээлтийг хүлээж байна.
 - **Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 682.0 сая төгрөгийн** 13 арга хэмжээ хэрэгжихээс 4 төсөл, арга хэмжээ Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 2 төсөл арга хэмжээ харьцуулалтын аргаар нийт 6 төсөл арга хэмжээ тендер зарлахаар төлөвлөсөн. Үүнээс 6 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зарлаж болж 1 төсөл арга хэмжээ үнэлгээ хийх шатанд 5 төсөл арга хэмжээний тендерийн нээлтийг хүлээж байна.
 - **Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 752.5 сая төгрөгийн** төсөвт өртөг бүхий 20 төсөл, арга хэмжээ хэрэгжихээс 4 төсөл, арга хэмжээ Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 6 төсөл арга хэмжээ харьцуулалтын аргаар, 2 төсөл арга хэмжээ зөвлөх сонгох бага үнийн аргаар нийт 12 төсөл арга хэмжээ тендер зарлахаар төлөвлөсөн. Үүнээс 9 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зарлаж 6 төсөл арга хэмжээнд үнэлгээ хийх шатанд 3 төсөл арга хэмжээний тендерийн нээлтийг хүлээж байна.
 - Мөн **27 суманд 3296.8 сая төгрөгийн** хөрөнгө оруулалт тус тусгагдлаа.
- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/607 дугаар захирамжаар батлуулж төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн цахим тендер шалгаруулалтын www.tender.gov.mn системээр батлуулж тендер шалгаруулалт зохион байгуулах эрхийг авсан. Батлагдсан төлөвлөгөөг нийтэд ил тод болгох ажлын хүрээнд Монголын Үнэн сонин 2021 оны 01 дүгээр сарын 11-ны №006 дугаарт, www.shilendans.gov.mn, www.tov.gov.mn, www.khural.mn сайтуудад байршуулан ажиллалаа.

Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн чиглэлээр:

Газар тариалангийн хүрээнд: Хаврын тариалалтын бэлтгэл ажлын явцын мэдээллийг бэлтгэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд өргөн барьж танилцуулсан.

Тариалалтын бэлтгэл ажлын явцын мэдээгээр энэ жил үр тариа 86.8 мянган га-д үүнээс улаан буудай 80.8 мян.га-д, төмс 10.0 мян.га-д, хүнсний ногоо 1.6 мян.га-д, тэжээлийн ургамал 35.8 мян.га-д, тосны ургамал 10.5 мян.га-д тариалалт хийхээр төлөвлөж, буудайн 7.6 мян.тн үрийг нөөцөлснөөс 80 хувийг шинжилгээнд хамруулж, стандартын шаардлага хангуулах арга хэмжээг авч, дутагдалтай байгаа 8.1 мян.тн үр, 1.6 мян.тн шатахуун, хүнсний ногооны 1600 га-д тариалахад шаардагдах үрийн хэрэгцээт үрийн захиалгыг тус тус ХХААХҮЯ-нд уламжилсан.

Энэ жилийн тариалалтад трактор нийт 910 зүтгэх хүч, үр тарианы 1140, төмсний 150, хүнсний ногооны 45 үрлэгч, сийрүүлэгч нийт 618 ажиллахаас техникийн засвар 85 хувьтай хийгдэж, тариалалт 5-р сарын 1-ны өдрөөс эхлэхээр бэлтгэл ажил хангаж байна.

Аймгийн хэмжээнд өвлийн болон зуны халаалттай 25600 мкв хүлэмжинд 12 нэр төрлийн 3.9 сая.ш үрслэг бойжуулан өвлийн хүлэмжийн тариалалт эхлээд байна.

Аймгийн Засаг даргын А/227 дугаар захирамжаар тариалалтын штабыг 13 хүний бүрэлдхүүнтэй байгуулж, штаб 4-р сарын 07-ны өдөр анхны хурлаа хийж зөвлөгөөн зохион байгуулах товийг тогтож, тариалалтын ажлын бэлтгэлийг хангуулах, буудайн үр нөөцөлсөн аж ахуйн нэгж, иргэний агуулахаас үрийн дээж авч шинжилгээнд хамруулах ажлыг эрчимжүүлэх шийдвэр гарсан.

Засаг даргын А/256 дугаар захирамжаар газар тариалангийн үйлдвэрлэлийн 2021 оны зорилтыг хангахаар сумдын тариалалтын штабыг байгуулж бэлтгэл ажлыг хангуулах, буудайн

үрийг шинжилгээнд хамруулж тарих үрийн чанар, стандартыг хангуулах, мэргэжил арга зүйгээр хангахаар 2 ажлын хэсэг томилогдож тариалангийн 14 сумдад ажилласан.

Буудайн үр нөөцөлсөн 68 аж ахуйн нэгж, иргэдийн үрийн дээжийг авч шинжилгээнд хамруулаад байна.

ХХААХҮЯ, НҮБ-ын ХХААБ-ын эрх зүйн орчин төслийн газраас “Пестицидийн бүртгэл хяналт, ургамлын гарал үүслийн системийг нэвтрүүлэх” цахим сургалтад 20 сумын газар тариалангийн мэргэжилтэнг хамрууллаа.

“Үр тарианы үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөн”, “Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөн”-ийг 4-р сарын 22-ны өдөр цахимаар зохион байгуулж, орон нутгийн телевизээр шууд нэвтрүүлсэн.

Тариалалтын зөвөлгөөнд аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, ХХААХҮЯ-ны газрын дарга, мэргэжилтэн, ХААДС-ийн дарга, мэргэжилтэн, УГТХ, УХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан нар оролцож тариалангийн талаар баримталж байгаа бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, үзүүлэх дэмжлэг, үр тарианы тариалалтад баримтлах ерөнхий зөвлөмж, дулааны улирлын цаг уурын төлөв, үр тариа, төмс, хүнсний ногооны ургамал хамгаалал, хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэл, жимс, жимсгэний хаврын арчилгааны талаар технологийн зөвлөмжийг 300 гаруй тариаланч, ногоочдод хүргэж ажиллаа.

Мал аж ахуйн хүрээнд: Мал аж ахуйн салбарын хаваржилт, төл хүлээн авах, хаврын тариалалтын ажилд болзошгүй хүндрэлээс урьдчилан сэргийлэх бэлтгэлийг хангуулах тухай аймгийн Засаг даргын 2021 оны 02 тоот албан даалгаврыг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд төллөх насны хээлтэгчийн 46.7% буюу 1077379 толгой хээлтэгч мал төллөж 1080564 толгой төл гарсаны 1060058 толгой төл бойжиж байна.

Нийт гарсан төлийн 1.8% буюу 20506 толгой төл мал хорогдсон нь өмнөх оны мөн үеэс 333 толгойгоор буурсан байна.

Мал аж ахуйн хаваржилт, төл хүлээн авах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын шийдвэрээр аюулгүйн нөөцийн өвсийг 30%-иар хямдруулж, 5 суманд 1238 шуудай тэжээлийг үйлдвэрийн үнээр борлуулаад байна.

Улсын төсвийн хөрөнгөөр бэлчээрийн хортон мэрэгчтэй 9-11-р сард энгийн механик аргаар 30.0 мянган га талбайд тэмцэх ажлыг хийхээр ХХААХҮЯ-амтай гэрээ байгуулан, тархалт, тандалт хөнөөлийн судалгааг Алтанбулаг, Аргалант, Баянхангай, Баяндэлгэр, Эрдэнэсант, Өндөрширээт, Лүн, Угтаалцайдам, Цээл сумдад хийлгэхээр УХСЭШХүрээлэнд саналаа хүргүүлсэн.

Нутгийн монгол Баянцагаан хонийг “Үүлдэр” болгох судалгааны ажлын хүрээнд ХААИСургуулийн эрдмийн зөвлөлийн 04-р сарын 15-ны өдрийн хурлаар хийсэн ажлын тайланг хэлэлцүүлэн, ХХААХҮЯ-аманд тайланг эцэслэн хүргүүллээ.

ХХААХҮЯ-ам, Азийн хөгжлийн банкны хамтын ажиллагааны хүрээнд 26 сумын 1500 малчин өрхөд хүнсний багцын тусламжийг хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.

Одоогийн байдлаар 40258 толгой том мал зүй бусаар хорогдоод байна.

Үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд: Аймгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийг тогтвортой байлгах зорилгоор “Хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээ, хангалт, нөөцийн судалгаа”-г сум тус бүрээр гарган, 7 хоногийн даваа, пүрэв гараг бүр ХХААХҮЯ-ам, аймгийн онцгой комисст тус тус хүргүүлэн ажиллаж байна. Одоогийн байдлаар мах 64.7 тн, гурил 102.5 тн, гурилан бүтээгдэхүүн 18.4 тн, төрөл бүрийн будаа 37.4 тн, ургамалын тос 13.2 тн, төмс 21830 тн, хүнсний ногоо 893.6 тн, элсэн чихэр 22 тн, давс 9.1 тн байгаа нь нийт мах 6 хоног, гурил 11 хоног, төмс 3427 хоног, хүнсний ногоо 38 хоногийн тус тус нөөцтэй байна.

Зуунмод сумын хүн амын хаврын махны хэрэгцээг хангах зориолгоор Эрдэнэ сумын “Эрдэнэ хүнс”ХХК хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж 15 тн хонины мах бэлтгэн нөөцөлж 04 дүгээр сарын 05 өдрөөс эхлэн 12.7 тн хонины махыг 6700 төгрөг буюу зах зээлийн үнээс 4300 төгрөгөөр хямдаар 10 худалдааны төвөөр иргэдийн хүнсний хэрэгцээнд зориулан борлуулсан.

“Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль”-ийн 20.2, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.8 –д заасаны дагуу жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын бүртгэл статистикийн мэдээлэлийн тогтолцоотой болох, олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор идэвхтэй үйл

ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийг бүртгэлжүүлэн, мэдээлэлийн сан бий болгох зорилгоор зорилгоор татвар төлөгч 722 аж ахуй нэгжийн судалгааг нэгтгэн ХХААХҮЯ-нд хүргүүлээ.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 10 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” дэд хөтөлбөрийн 5 зорилт 32 арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн 85 хувийн явцтайгаар Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр өргөн бариад байна.

Стандарт хэмжил зүйн чиглэлээр:

Тохирлын гэрчилгээ шинээр авах буюу сунгуулахаар хүсэлт ирүүлсэн 35 аж ахуйн нэгж, иргэний бүтээгдэхүүн, үйлчилгээ 2 дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамрууллаа. Шинэчлэгдэн батлагдсан хүнсний ногооны стандартын талаар (байгууллагын вэб сайт, Төв аймгийн хэвлэл мэдээллийн алба аймгийн төрийн албан хаагчдын www.intranet.gov.mn дотоод удирдлагын систем)-ээр нийт 400 орчим хэрэглэгчдэд мэдээллээр ханган ажиллаа.

Хэмжил зүйн лаборатори нь Үнэт металын 1ш, Сэргэлэн сумын худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн 3ш, Зуунмод сумын Андүүд худалдааны төвийн худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн 13 нийт мөнгөн тооцоонд ашигладаг 17ш хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулсан.

Цахилгаан хэмжүүрийн баталгаажуулалтын төрлөөр УБЦТС ХХКомпанитай байгуулсан гэрээний дагуу Зуунмод сумын айл өрх, аж ахуй нэгжийн нийт 111 ш 1 фазын бүрэн электрон цахилгаан тоолуурыг шалгаж баталгаажууллаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хүрээнд:

Уул уурхай, хяналт шалгалтын чиглэлээр:

Аймгийн Засаг даргын баталсан Хууль бусаар ашигт малтмал олборлохоос урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд аймгийн ХОХБТХ, БОАЖГ, ЦГ, ГХБХБГ, МХГ-уудтай хамтран 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Сэргэлэн сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй “Үүрт гоулд” ХХК, “Газрын хүдэр” ХХК-иуд болон тухайн багийн нутагт цуглараад байгаа хууль бус гар аргаар ашигт малтмал олборлож буй иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж гүйцэтгэлээ.

Шалгалтаар уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч тус 2 аж ахуйн нэгжид баримт бичгийг бүрдүүлэн мөрдөж, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах, КОВИД-19 цар тахлын үед халдвар хамгааллын дэглэмийг баримталж ажиллах талаар улсын байцаагчийн Зөвлөмжийг хүргүүлж ажилласан.

Баримт бичгийн бүрдэл дутуу батлагдсан уулын ажлын төлөвлөгөөгүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй үйл ажиллагаа эхлүүлж байна. “Үүрт гоулд” ХХК-ийн үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар зөрчил арилгах хүртэлх хугацаагаар зогсоов.

Хууль бус гар аргаар ашигт малтмал олборлосон иргэдийн газрын хэвлийг хөндсөн газарт үзлэг, хэмжилт хийхэд 2000м², 7500м² хэмжээтэй 2 хэсэг газрын хөрсийг 10-15см зузаантайгаар хуулан авсан байна.

Шөнийн цагаар Төв, Дархан уул аймаг, Багануур, Налайх, Багахангай дүүрэг гэх мэт газар газраас 100 орчим тээврийн хэрэгсэл 300 гаруй иргэд цугларч шороо зөөвөрлөж буй иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоож 3 тээврийн хэрэгсэл 5 иргэнийг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлж ажилласан.

Хамгаалах цөлжилтийн чиглэлээр:

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 318-р тогтоолоор батлагдсан “Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 3 зорилт, 17 арга хэмжээтэйгээр аймгийн Засаг даргын А/230 тоот захирамжаар батлууллаа. Захирамжын дагуу “Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах” арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтын хамт сумдад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар чиглэл өгч ажиллаа.

Ойн бодлогын талаар:

“Төрөөс ойн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний 2 дугаар үе шатны төлөвлөгөөний төслийг боловсруулан, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээ.

Ногоон төгөл-Ногоон паспорт цэцэрлэгт хүрээлэнд үхэрээ зориуд удаа дараа оруулсан Ланс 2 дугаар багийн иргэн Б.Мөнхбаярын зөрчлийг Зуунмод сумын БОХУБайцаагчид шилжүүлэн өгч, Зөрчлийн тухай хуулиар 150,0 мян төгрөгөөр захиргааны арга хэмжээ авахуулсан.

Хог хаягдлын чиглэлээр:


Аймгийн хэмжээнд Алтанбулаг, Баянцагаан, Баян-Өнжүүл, Заамар, Лүн, Мөнгөнморьт, Өндөрширээт, Сүмбэр, Сэргэлэн, Эрдэнэсант зэрэг сумдад 25 ААН болон 467 иргэнийг хамруулан

нийтийн цэвэрлэгээ зохион байгууллаа. Уг ажлын хүрээнд голын эрэг дагуух цэвэрлэгээ, нийтийн эзэмшлийн талбай, айл өрх ойр орчмын газраа, мөн жалга гууг цэвэрлэн 237 үхсэн малын сэг зэм, 60 нохой устгалын сэгийг тус тус цэвэрлэн нийтдээ 94,4 тн хогийг төвлөрсөн хогийн цэгт булж устган ариутгалын ажлыг хийсэн байна.


Ус, цаг уур, орчны шинжилгээний чиглэлээр:

Төв аймгийн 2021 оны 03 дугаар сарын цаг уурын тойм

Агаарын дундаж температур: Нийт нутгаар $-5.6^{\circ}\text{C} \dots -0.4^{\circ}\text{C}$ байснаас Мөнгөнморьт, Эрдэнэ сумдад $-5.3^{\circ} \dots -5.6^{\circ}\text{C}$, Эрдэнэсант суманд -0.4°C байлаа. /Зураг-1/ **Олон жилийн дундажтай харьцуулахад:** Нийт нутгаар $4.8^{\circ}\text{C} - 7.1^{\circ}\text{C}$ -аар дулаан байлаа. /Зураг-2/



/ Зураг-1/




/ Зураг-2/

Хөрсний дундаж температур: Нийт нутгаар 3°C хүйтнээс 1°C дулаан байснаас Зуунмод, Угтаал, Эрдэнэ суманд -3°C , Лүн суманд 1°C байлаа.


Агаарт 30°C -аас хүйтэн өдөр, хөрсөнд 40°C -аас хүйтэрсэн өдөр нийт нутгаар ажиглагдаагүй.

Агаарын температурын үнэмлэхүй их утга $+11.4^{\circ}\text{C} \dots +17.5^{\circ}\text{C}$ байснаас Өндөрширээт суманд $+17.5^{\circ}\text{C}$, хөрсний үнэмлэхүй их утга $+19^{\circ}\text{C} \dots +36^{\circ}\text{C}$ байснаас Лүн суманд $+36^{\circ}\text{C}$ ажиглагдсан бол агаарт үнэмлэхүй бага утга: $-27.9^{\circ}\text{C} \dots -16.5^{\circ}\text{C}$ байснаас Мөнгөнморьт суманд -27.9°C , хөрсөнд үнэмлэхүй бага утга: $-29^{\circ}\text{C} \dots -19^{\circ}\text{C}$ байснаас Алтанбулагт -29°C , Угтаал суманд -28°C ажиглагдлаа.

Тунадасны хувьд: Нийт нутгаар 0.0-7.1 мм тунадас орсон, хамгийн их нь Борнуур суманд 7.1 мм, Баян-Өнжүүл, Бүрэн, Баянцагаан, Дэлгэрхаан, Өндөрширээт сумдад 0.0 мм, Баян суманд тунадас ороогүй. /Зураг-3/



/ Зураг-3/



/ Зураг-4/

Олон жилийн дундажтай харьцуулахад Баянчандмань, Борнуур, Замар сумдын нутгаар дунджаас ахиу, Лүн, Цээл сумдын нутгаар орчим бусад сумдын нутгаар дунджаас бага тунадас орсон. /Зураг-4/

Салхины дундаж хурд: нийт нутгаар 1.7-5.0 м/с байснаас Дэлгэрхаан суманд 5.0 м/с, Батсүмбэр, Цээл суманд 1.7 м/с байв. **Салхины их хурд:** 14-32 м/с ажиглагдсанаас Бүрэн суманд 32 м/с хүрч салхилсан. **10 м/с-ээс их хурдтай өдрийн тоо:** 4-2 өдөр байснаас Дэлгэрхаан сумын нутгаар 22 өдөр, Жаргалант, Батсүмбэр сумдын нутгаар 4 өдөр ажиглагдсан байна. **15 м/с-ээс дээш хурдтай өдрийн тоо:** 2-9 өдөр байсны 9 өдөр нь Зуунмод суманд ажиглагдлаа.

Цасан бүрхүүл: Алтанбулаг, Зуунмод, Эрдэнэ, Баянчандмань, Мөнгөнморьт, Угтаал, Борнуур, Цээл, Жаргалант сумдын нутгаар 1 дүгээр 10 хоногт 10 балл цастай, цасны өндөр 0-6 см байсан ба, Баян-Өнжүүл, Эрдэнэсант, Лүн, Заамар сумдын нутгаар сарын эхэнд 1-4-нд 4-10 балл цастай, цасны өндөр 0-5 см, Батсүмбэр суманд 1-19-ний өдрүүдэд 2-10 балл цастай, цасны өндөр 0-5 см байсан. Дэлгэрхаан, Бүрэн, Баянжаргалан, Баян, Өндөрширээт, Баянцагаан сумдын нутгаар цасгүй байсан.

Урьдчилан мэдээлэх: Нарийвчилсан мэдээ, 1 хоногийн мэдээ, 5 ба 7 хоногийн мэдээ, сарын болон улирлын мэдээ, өнгөрсөн 1 болон 7, 10 хоног тутмын цаг агаарын тойм мэдээг тус тус гаргаж, И-мэйл-ээр дамжуулж, www.tuv.tsag-agaar.gov.mn сайт, TuvTsaguur page-д байршуулан, өдөр тутмын цаг агаарын мэдээг Зуунмод сумын ОНИМ-ийн ажилтанд И-мэйл ба “Дотоод удирдлагын систем”-ээр явуулах ажил тасралтгүй хийгдэж, төв талбай болон байгууллагын урсдаг гэрлэн самбарт нарийвчилсан, хоногийн мэдээг өдөр бүр байршуулан ард иргэдэд үйлчилж байна. 04 дүгээр сарын 10, 13-нд Төв аймгийн нутгаар нойтон цас орж, цасан шуурга шуурахыг анхааруулах болон сэрэмжлүүлэх мэдээг 12-48 цагийн өмнө 4 удаа нийт 21530 хэрэглэгч (малчид, ард иргэд)-ийн гар утсанд Багц мессежээр мөн www.tuv.tsag-agaar.gov.mn сайт, TuvTsaguur page-д байршуулан үйлчиллээ.

Байгаль орчны шинжилгээний лаборатори: Агаарын чанарын хүхэрлэг хий, азотын давхар ислийн сорьц авч шинжилгээг хийн агаарын чанарыг тодорхойлж байна. Агаарын чанарын ажиглалтыг 04 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар нийт 48 удаа хийсэн ба хүхэрлэг хийн дундаж агууламж 0.007 мг/м^3 азотын давхар ислийн дундаж агууламж 0.007 мг/м^3 үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүхэрлэг хийн дундаж агууламж 0.002 мг/м^3 -ээр нэмэгдсэн, азотын давхар ислийн дундаж агууламж өөрчлөлтгүй гарсан байна.

Гадаргын усны чанар: Усны чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу 04 дүгээр сард Туул-Лүн, Шивэрт-Борнуур, Туул-Заамар голуудын хяналт шинжилгээний цэгээс усны сорьц авч химийн найрлага, чанарын үзүүлэлтүүдийг тодорхойллоо. Шинжилгээний дүнгээс үзэхэд голын усны эрдэсжилт Туул-Лүн-139 мг/л, Шивэрт-Борнуур-279 мг/л, Туул-Заамар-189 мг/л байсан ба голын ус органик бодисын болон эрдэс азотын бохирдолгүй, цэвэр байсан.

Ус судлалын салбар: Төв аймгийн нутаг дэвсгэрт 7-н ус судлалын харуул ажиллаж байгаагаас 2021 оны 04 дүгээр сарын 21-ний байдлаар усны түвшин: Хэрлэн голын Хэрлэн-Мөнгөнморьт-190 см, Хэрлэн-Хонгон харуулд-219 см ба Туул голын Туул-Алтанбулаг харуулд -528 см, Туул-Лүн харуулд-106 см, Туул-Заамар харуулд-140 см, Сөгнөгөр гол Сөгнөгөр-Сөгнөгөр харуулд 250 см, Шивэрт гол Шивэрт-борнуур харуулд 139 см тус тус байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад Туул-гол Лүн, Заамар харуулд 27 см-ээр бага Алтанбулаг харуулд 16 см их, Хэрлэн гол 7-39 см их, Сөгнөгөр гол 48 см бага, Шивэрт голын усны түвшин 1 см бага түвшинтэй байна.

Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:

1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас 27 сумын 396 эхийн материал хүлээн авч, хянан Засаг даргын зөвлөлийн хурал болон 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 04 дүгээр хурлаар хэлэлцүүлэн 25 дугаар тогтоолоор 392 эхийн материалыг Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүллээ.
2. Мэргэжлийн боловсрол, сургалтын аймгийн салбар хороо 2021 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр хуралдаж 2020 оны үйл ажиллагааны хэрэгжилт, 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, 2021-2022 оны хичээлийн жилд элсэгчдийн 1085 хяналтын тоог хэлэлцэн батлууллаа.
3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн салбар хороо 2021 оны 04 сарын 21-ний өдөр 88.2 % ирцтэйгээр хуралдаж 2020 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, үр дүнг танилцуулан хэлэлцэж 2021 оны төлөвлөгөөг батлууллаа.
4. “Хүүхэд бүр цэцэрлэгт”, “Хөгжсөн багшаас чадварлаг сурагч” “Хүүхдийн хүмүүжил төлөвшлийг сайжруулах”, “Хүүхдэд ээлтэй дотуур байр” дэд хөтөлбөрүүдийн 2 үе шатны төлөвлөгөөг ЗДЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, аймгийн ЗД-ын 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/259 дүгээр захирамжаар батлууллаа.
5. “Сонгодог урлаг-III” аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал болон ИТХ-ын Тэргүүлэгчдийн 04 дүгээр сарын 08-ны цахим хуралдаанаар хэлэлцүүллээ. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 04 дүгээр сарын 08-ны өдрийн 04 дүгээр тэмдэглэлээр тус хөтөлбөрийн хүрээнд 4 чиглэлээр үүрэг даалгавар өгөөд байна.

6. Аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн, 04-12-ны өдөр салбар зөвлөлийг хуралдуулж, 2020 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2021 онд хэрэгжүүлэх “Өв соёлоо эрхэмлэж, үндэсний бичгээ сурцгаая” аяны удирдамж, үйл ажиллагааны төлөвлөгөө, “Төв аймгийн сайхан бичигтэн -Төрийн албан хаагч”, “Үндэсний бичгийн тэргүүний уншигч”, “Монгол бичигтэн байгууллага”, “Үндэсний бичгээ дэлгэрүүлэгч багш, сурагч” уралдааны болзол, Төрийн албан хаагчдад зориулсан үндэсний бичгийн анхан, дунд шатны модуль сургалтын хөтөлбөр, “Үндэсний бичиг үсгийн баярыг тэмдэглэх үйл ажиллагааны төлөвлөгөө” зэргийг хэлэлцүүлэн батлууллаа. Мөн сумдын хэлний бодлогын салбар зөвлөлийг чадавхжуулах цахим сургалтыг зохион байгуулж чиглэл өглөө. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албатай хамтран аяныг үр дүнтэй зохион байгуулах, иргэд олон нийтэд сурталчлах, үндэсний бичиг үсгийн баярыг угтсан “Төв соёл” теле нэвтрүүлгийг бэлтгэлээ.

Боловсролын салбар:

1. БСУГ-ын мэргэжилтнүүд Ахисан түвшний жендерийн дүн шинжилгээ, Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт шинжилгээ үнэлгээ, Монгол бичгийн сургалтад 90-100% цахимаар хамрагдаж мэргэжил боловсролоо дээшлүүлээ.
2. Орон нутгийн мэргэжлийн бүлгийг 6 бүсийн төвийн цэцэрлэгийг түшиглэн байгуулж, бага, дунд, ахлах, бэлтгэл бүлгийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн шинэ санааг цэцэрлэг бүр боловсруулан “Тэргүүн туршлага” цахим санд 168 арга зүй нэгтгэн, мэргэжлийн бүлгийн хэлэлцүүлгийг 4 удаа зохион байгуулж, харилцан туршлага солилцох ажлыг зохион байгуулсан.
3. СӨБ-д ажиллагсдын ёс дүрмийг хэрэгжүүлэх, аливаа ёс зүйн алдаа гаргахаас урьдчилан сэргийлэх зорилго бүхий “Хүүхдийн хүмүүжлийн эерэг аргууд” 48 цагийн модуль сургалтыг 8 цагийн сургалт болгон багцлан 4 бүлэг сэдвийн хүрээнд орон нутгийн түвшинд 2 бүс болгон 2 өдөр зохион байгуулж 47 цэцэрлэгийн 36 эрхлэгч, 10 арга зүйч, 107 багш, 74 туслах багш, 61 үйлчилгээний ажилтанг хамруулан зохион байгууллаа.
4. Цаг үеийн нөхцөл байдлын талаарх мэдээг өдөр бүр 12 цагт БШУЯ-нд 5 асуулга бүхий хүснэгтээр хүргүүлсэн байна. Үүнд: Цэцэрлэгийн 781 ажиллагсдаас багш 152, бусад ажиллагсад 377 буюу 67.7% I тунгийн вакцинд хамрагдсан. Сургалтын үйл ажиллагаа түр хаагдсан 47 цэцэрлэг\Хөл хорионд 5842 хүүхэд байна. Ковид 19 цар тахлаар нийт 11 ажилтан, 6 хүүхэд өвдсөн. Теле хичээлийн хамрагдалт 4932 хүүхэд буюу 84%-тай байна.
5. Аймгийн хэмжээнд 2021 онд ЭЕШ өгөхөөр өдрийн ангийн 598 суралцагч \2021.04.26-ны байдлаар\ бүртгүүлсэн байна. ЭЕШ-ын үр дүнг ахиулах зорилгоор 27 сумын ЕБС-ийн захирал, сургалтын менежерүүдтэй цахим уулзалт зохион байгуулж ЭЕШ-д бэлтгэх сорил авах, багш нар хамтран хөгжих мэргэжлийн бүлгийг ажиллуулахад анхаарах асуудал болон багш нарт ур чадварын нэмэгдэл олгох тухай БШУС, ХНХС, Сангийн сайдын хамтарсан А\35\А\10\9 тоот тушаалын танилцуулга хийж мэдээлэл өглөө.
6. МУИХ-ын 2015 оны Монгол хэлний тухай хууль, МУЗГ-ын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III” ийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын 2021 оны “Аймгийн хэлний бодлогын Салбар зөвлөлийг шинэчлэн батлах тухай” А/241, “Монгол хэлний талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” А/246 дугаар захирамжуудыг батлууллаа.
7. “Үдийн цай” хөтөлбөрийг “Үдийн хоол” хөтөлбөрт шилжүүлэх ажлын хүрээнд Хүмүүн цогцолбор сургуулийн их засварын ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Их засварын ажлын гүйцэтгэл 100% , тоног төхөөрөмж нийлэх ажлын гүйцэтгэл Ковид -19 цар тахалын улмаас тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон байгаа.
8. Дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн судалгаа, Зуунмод сумын Здотуур байр, МСҮТ, байрны ор болон зөөлөн эдлэлийн судалгаа, сумдын дотуур байр шинээр барих болон өргөтгөл шинэчлэл их засвар хийх эрэмбэ дарааллын судалгаа, ЕБС, Цэцэрлэг, Дотуур байранд ариутгал халдваргүйжүүлэлтийг хэрхэн хийж буй судалгаа, ЕБС, Цэцэрлэг, Дотуур байрыг тусгаарлах байр, эмнэлгийн ор дэлгэх вакцинжуулах төв, PCR- шинжилгээний цэгээр ашиглаж байгаа эсэх судалгаа болон сумдын 29 дотуур байрны план зураг авч нэгтгэн холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.
9. ЕБС-ийн багш нарын дунд Багшлахуйн сайн туршлагыг илрүүлэн түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулсан “Дэлхийн том хичээл-Тогтвортой хөгжлийн боловсрол ” үндэсний хэлэлцүүлгийн 1 дүгээр шатанд 15 багийн 18 нэгж болон ээлжит хичээлийн хөтөлбөрийг хэлэлцүүлээ. 1-р байранд Жаргалант сумын ЕБС “Хог ч гэсэн гэртэй-

Өөрчлөлтийг өөрөөсөө” сэдвийн нэгж хичээлийн хөтөлбөр, 2-р байранд Зуунмод-4-р сургуулийн “Бяцхан нисгэгчид-Батарей аюултай юу” сэдвийн нэгж хичээлийн хөтөлбөр, 3-р байранд Лүн сумын ЕБС-ийн “Цөлжилт-Хүүхэд бидний оролцоо” ээлжит хичээлийн хөтөлбөрүүд шалгарч улсын сайн хичээлд оролцохоор боллоо.

Насан туршийн боловсрол:

1. Насан туршийн боловсрол төвийн вэйб цахим хаягтаа хийсэн ажлуудаа байршуулан ажиллаж байна.
2. Насан туршийн боловсролын үндэсний төвөөс салбарын багш нарын мэдлэг, ур чадвар, заах арга зүйг дээшлүүлэх зорилгоор Гоо зүйн боловсролын хоёр дахь багц сургалтыг 2021 оны 4 сарын 19-22-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж 21 аймаг, 9 дүүргийн НТБ-ын багш нарыг хамруулах сургалтад хамрагдлаа.
3. Насан туршийн боловсролын үндэсний төвийн удирдлагууд 2021 оны 4 сарын 22-ны өдөр Төв, Дорноговь аймгийн насан туршийн боловсролын багш нартай онлайнаар уулзаж, цар тахлын үеийн сургалт, үйл ажиллагаатай танилцаж туршлага солилцлоо.
4. Бага, суурь, бүрэн дунд боловсролын нөхөн олгох хөтөлбөрийн танилцуулах сургалтад оролцлоо.

Монгол туургатан театр:

1. 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр “Витаминжуулалтын аяныг дэмжицгээе” хандивын аяныг аймгийн ЗДТГ, Төв телевизтэй хамтран өөрийн байранд цахимаар амжилттай зохион байгуулж, 60.371.000 төгрөгийн хандивыг бүрдүүлэн ажилласан байна.
2. Захиргаа аж ахуйн ангийн албан хаагчид 2021 оны 04 дүгээр сарын 02, 08, 16, 23-ны өдрүүдэд байгууллагын гадна орчны цас, хог, дотор их цэвэрлэгээг тогтмол хийж ажилласан.
3. 2021 оны 04 дүгээр сарын 07, 04 дүгээр сарын 23-ны өдрүүдэд буюу 2 удаа байгууллагад мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэлт, ариутгалыг хийлгэсэн.
4. “Монголын сонгодог, Ардын хөгжим I, II, уртын дуу, хөөмий гэсэн сэдэвт 6 контентыг шинээр бэлтгэн хийж, 3 удаагийн давтамжтайгаар аймгийн Төв телевиз болон Монгол туургатан театрын пэйж хуудсаар дамжуулан иргэдийн хүртээл болгож байна.
5. Соён гэгээрүүлэх ажлын хүрээнд “Монголын өв соёл-Ардын дуу, хөгжим, бүжиг” сэдвийн хүрээнд 15 удаагийн нэвтрүүлгийг Төв телевизтэй хамтран хийж, иргэдэд хүргэлээ.

Нийтийн номын сан:

1. Монголын залуучуудын байгууллага үүссэний 100 жилийн ойн хүрээнд Төв аймгийн залуучуудын холбооноос “Номтой нөхөрлөө” аяныг санаачлан эхлүүлж, энэхүү аяны хүрээнд “Номын тэмдэглэл” хөтлөх бичлэгийн уралдааныг Нийтийн номын сан хамтран зохион байгуулж байна.
2. Номын сангийн сан хөмрөгт байгаа уран зохиол, мэргэжлийн болон хүүхдийн зохиолын номнуудыг Дотоод удирдлагын системээр олон нийтэд долоо хоног бүрийн Даваа гарагт танилцуулж байна. 4-р сард нийт 3 номын танилцуулга хүргэсэн.
3. Номын сан нь барилгын засвар шинэчлэл хийж чөлөөт сонголтын уншлагын танхим болохтой холбогдуулан ном алдаж үрэгдэхээс урьдчилан сэргийлж “Гэрээр олгох танхим”-ын номыг тоолж электрон каталоги, нэг бүрчилсэн бүртгэлтэй тулгалт хийлээ. Нийт 11753 ном тооллоо.
4. ХАБЭА-н сарын аяны хүрээнд зохион байгуулсан цахим сургалтад Нийтийн номын сангийн албан хаагчид хамрагдаж Ажлын байранд Ковид-19 халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан ажилтны эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр “Эрсдэлийг урьдчилан тооцоолж, эрүүл аюулгүй ажиллах нь” стандартуудын талаар мэдээ мэдээллийг авлаа.
5. Зуунмод сумын ИТХ-ын Байгаль орчин газрын харилцаа хариуцсан хорооноос Зуунмод сумын нутаг усаа гэсэн сэтгэлтэй иргэдийн дунд “Нэг хүн-нэг шуудай хог” челленжид номын сангийн хамт олон нэгдэж цэвэрлэгээ хийлээ.
6. “Эх хэл хүүхдийн ертөнц” уралдааныг БСУГ, ДЗТОНХХөтөлбөр, Нийтийн номын сан хамтран Төв аймгийн 27 сумын ЕБС-н бага ангийн сурагчдын дунд 2020 оны 11 сараас эхлэн зохион

байгуулж 2021 оны 4 дүгээр сарын 30 өдрөөр тасалбар болгон хэрэгжилтийг гарган шагнаж урамшуулна.

Биеийн тамир спортын газар:

1. ЗГ-ын тохируулагч агентлаг БТСУХ-ноос зохион байгуулсан цахим гүйлт-2021 арга хэмжээнд Төв аймгийн тамирчид амжилттай оролцож эмэгтэйчүүдээс Баянхангай сумын тамирчин Э.Золжаргал 762.8 км зам туулж Төвийн бүсдээ 1-р байр улсад 5-р байр, аймагтаа 1-р байр эзэлж шилдгийн шилдэг тамирчин, Баянхангай сумын тамирчин М.Оюунтүлхүүр 618.8 км зам туулж улсад 8-р байр, Төвийн бүсдээ 2-р байр, аймагтаа насандаа 1-р байр, БТС-ын Газрын дасгалжуулагч Э.Цагаандарь 703.0 км зам туулж Төвийн бүсэд 3-р байр, улсад 13-р байр аймагтаа 1-р байр эзэлсэн амжилтуудыг үзүүллээ.Энэ арга хэмжээнд Төв аймаг 911 хүнийг хамруулж 24.179 км-ын замыг туулж улсад 4-р байр, төвийн бүсдээ 2-р байрыг эзэллээ.
2. Ажлын байран дахь сургалтад 20 хүнийг хамруулан 14 хүн сертификат авч идэвхтэй хөдөлгөөнд 911 хүнийг хамруулсан
3. Коронавирус “КОВИД-19” халдвараас сэргийлэх арга хэмжээний хүрээнд иргэдийг вакцинжуулах ажлыг манай байгууллага дээр зохион байгуулах үед цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгалыг стандартын түвшинд хийж гүйцэтгэсэн.
4. Гамшгийн үеийн нөхцөл байдлыг хохирол багатай даван туулах, цаг агаарын аюулт үзэгдлээс хохирол учирсан айл өрхөд туслах зорилгоор төрийн албаны зөвлөлөөс гаргасан уриалгын дагуу хандив цуглуулан шефийн харилцаатай Баянхангай сумын онцгой комисст 600.000 төгрөгийг гардуулан өгсөн.
5. Зуунмод сумын ЗДТГ-аас зохион явуулсан “Нэг хүн-Нэг шуудай хог” чөлөнжид нэгдэн төв цэнгэлдэх хүрээлэн байгууллагын орчин тойрны хог хаягдлыг цэвэрлэн эрүүл орчинд идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэхийг иргэдэд уриалан 21 шуудай хог түүсэн.

Музей:

1. Музейн үзүүллэгийн 4 буюу Түүхийн танхимын үзүүллэгийг буулгаж, танхимыг засварлах ажил хийгдэж байна
2. 4-р сард музейн үзмэрийн RCH программд нийт 71 үзмэрийн тодорхойлолтыг нэмж оруулан 19.4 хувьтай байсныг 21.8 хувь болгож нэмэгдүүлээд байна..
3. 2021 онд аймгийн ИТХ-ын тогтоолоор ТСҮХДурсгалыг сум, орон нутгийн хамгаалалтад авах ажлын хүрээнд орон нутаг, сумдаас хамгаалалтад авах дурсгалын жагсаалтыг саналаар авахад 13 сумын 40 дурсгал ирсэн бөгөөд уг дурсгалын судалгаа хийж байна.

Нийгмийн даатгалын хэлтэс:

1. Хяналт шалгалтын чиглэлээр:

Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн 6 өргөдөл, гомдол, 9 албан бичиг хүлээн авч 5 өргөдөл хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариу өгсөн, 1 өргөдөл, 1 албан бичгийн шийдвэрлэх хугацаа болоогүй.

Хэлтсийн даргын баталсан “Дотоод аудитын төлөвлөгөө”-ний дагуу “Орон тооны бус зөвлөлийн дүрмийн хэрэгжилт, зөвлөлийн гаргасан тогтоолын үндэслэлд хяналт шалгалт хийх тухай”, “Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журмын хэрэгжилт, тэтгэмж авагчийн тэтгэмжийн тооцоолол, бодолт, олголт” чиглэлээр удирдамж боловсруулан хяналт шалгалт хийсэн. Дээрх удирдамжуудын дагуу хяналт шалгалт хийгдэж байгаа бөгөөд сумдын Орон тооны бус зөвлөлд цаашид хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж, чиглэлийг хүргүүлсэн.

Тэтгэвэр олголтыг цахимаар хянах ажлын хүрээнд тэтгэвэр олголтыг шалгаж 8 тэтгэвэр авагчийн хөдөлгөөн Улсын бүртгэлийн байгууллагын мэдээллээс зөрүүтэй хийгдсэн зөрчлийг илрүүлж, илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмжийг байцаагч нарт тухай бүр өгч ажиллалаа.

Баянчандмань сумын иргэн Тайж овогт Батбямбын Алтан-Очирын 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 28 дугаартай Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн улсын байцаагчдын “Илүү олгосон тэтгэврийг санд буцаан төлүүлэх тухай” актыг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлтэй шүүх хуралд оролцсон.

Сүмбэр суманд газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа “Таван эрдэнэ” ХХК-ний /РД:3856267/ нийгмийн даатгалын шимтгэлийн 5,097,990.49 төгрөгийн өрийг барагдуулах шүүгчийн захирамж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудасны дагуу ажиллагаа явуулахаар Төв

аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлж 5,097,990.49 төгрөг 100 хувь барагдуулж ажиллалаа.

2. Нийгмийн даатгалын сангийн чиглэлээр:

Засгийн газрын 2020 оны “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 247 дугаар тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/34 дугаар тушаалын дагуу 500 гаруй ажил олгогч, 5400 орчим сайн дурын даатгуулагчдад шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх ажлыг хэрэгжүүлэн ажиллаж, эхний дөрвөн сарын байдлаар ажил олгогчдод 430,5 сая төгрөг, сайн дурын даатгуулагчдад 313,4 сая, нийт 743,9 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлээд байна.

4 дүгээр сард эрүүл мэндийн даатгалд 238 малчин хамрагдаж 14,2 сая, ажил хөдөлмөр эрхлээгүй 23 даатгуулагчийн 1,4 сая, нийт 15,6 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлсэн. Жирэмсэн амаржсаны тэтгэмж 18 даатгуулагчид 46,1 сая, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 17 даатгуулагчид 6,8 сая, ажилгүйдлийн тэтгэмж 29 даатгуулагчид 34,3 сая, ҮОМШӨ-ний тэтгэмж 2 даатгуулагчид 3,6 сая, нийт 66 даатгуулагчид 90,8 сая төгрөг олгосон ба 16887 тэтгэвэр авагчдад 5957,0 сая төгрөгийн тэтгэврийг банкаар дамжуулан, сарын эхэнд олгон ажилласан.

3. Дотоод үйл ажиллагааны чиглэлээр:

Аймгийн нэгдсэн төлөвлөгөө, 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, урианы жилийн эхний улирлын хэрэгжилтийг гарган хүргүүлсэн. Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн лавлагаа 7 иргэн, цалингийн лавлагаа 40 иргэн, нийт 49 иргэнд лавлагаа олгон ажиллалаа.

Нийгмийн даатгалын ерөнхий газар, “ITZONE” ХХК-тай хамтран Нийгмийн даатгалын мэдээллийн GreenERP цахим систем нэвтрүүлэхээр зохион байгуулж буй сургалтад хэлтсийн 8 албан хаагчийг хамруулсан. Уг сургалт 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс 05 дугаар сарын 10-ны өдөр хүртэл цахимаар болно.

Төрийн албаны салбар зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлд 04 дүгээр сарын 23-ны өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр, албан хаагчдын анхаарах асуудлын талаар цахим сургалт зохион байгуулах санал тавьж, хэлтсийн төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний нийт 47 албан хаагчийг хамруулав.

Монгол улсын Сангийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 246-А/245 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн маягт хөтлөх журам шинэчлэн батлагдсан мөн нийгмийн даатгалын тухай хуулиудад хийгдсэн өөрчлөлт шинэчлэлт, аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогч нарт тулгарч буй асуудалтай холбоотойгоор “Зөвлөө-Тусалъя” цахим сургалтыг 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 05 дугаар сарын 05-ны өдөр хүртэл 873 байгууллагын нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтан нарыг хамруулан зохион байгуулахаар ажиллаж байна.

4. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын чиглэлээр:

Нийгмийн даатгалын ерөнхий дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссоос 03 дугаар сарын 17-ны өдрийн 25 дугаар албан бичгээр дотоодын хяналтыг эрчимжүүлэх чиглэлээр хугацаатай үүрэг даалгавар өгсөн бөгөөд уг үүргийн дагуу удирдамж гарган, баталж дахин магадланг нийт 644 иргэнд хийж байна. Үүнд: гэмтлийн чиглэлээр 219 иргэн, халдварт, сүрьеэгийн чиглэлээр 96, нүдний чиглэлээр 329 даатгуулагчийг дахин магадалсан.

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар:

Сарын онцлох ажил:

Аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хорио цээрийн дэглэмтэй байгаа хугацаанд хүүхэд багачууд, гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжих, эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ хөгжил төлөвшилд үр дүнтэй цагийг зарцуулах, хамтдаа бүтээж, хөгжихөд дэмжлэг үзүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд “**ХӨЛ ХОРИОГ-ХӨГЖИЛ БОЛГОЁ**” 14 хоногийн аяныг 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс 04 дүгээр сарын 30-ыг хүртэл дараах ангиллаар зарлаж, материалыг хүлээн авч байна. Үүнд:

- Цэцэрлэгийн нас
- 1-5 анги

- 6-8 анги
- 9-12 анги
- Оюутан, залуучууд
- Гэр бүл

Аяны хүрээнд аймгийн телевизүүдтэй хамтран “Ном уншлагын цаг” булан ажиллуулж, 7 үлгэрээр нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд түгээсэн.

Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр:

1. Коронавируст цар тахлын дэгдэлт хүүхдүүдийн дунд өндөр байгаа Алтанбулаг, Аргалант сумын 19 өрхийн 33 хүүхдэд хүнсний тусламж, дотуур байр болон гэртээ эмчлүүлж буй 89 хүүхдэд дархлаа дэмжих амин дэмийн багцын тусламжийг үзүүлсэн.
2. Засгийн газраас Ковид -19 цар тахлын хүндрэлийг даван туулах зорилгоор иргэн бүрт олгож буй 300000 төгрөг болон хүүхдийн мөнгөн тэтгэмж 100000 төгрөгийг хүүхэд, асран хамгаалагч нь авч чадахгүй байгаа Баян, Жаргалант, Өндөрширээт сумын 4 өрхийн 10 хүүхдийн асуудлыг Хүүхдийн төлөө зөвлөлтэй зөвшилцөн, ХААН банк, Төрийн банк, Хас банкинд албан тоот хүргүүлж, 6 хүүхдийн асуудлыг бүрэн шийдвэрлэлээ.

Гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр:

1. Коронавирусын цар тахлаар 60 наснаас дээш ахмадууд, архаг хууч өвчтэй хүмүүс өвчлөх, улмаар амь насаа алдах эрсдэл өндөр байгаа энэ үед сар бүрийн эхний 7 хоногийн Баасан гариг буюу “ГЭР БҮЛИЙН ӨДӨР”-өөр “Ахмад настнуудын сэтгэл санааг хэрхэн дэмжих вэ?” гэр бүл, ойр дотных нь тэднийг илүү ойлгох, сэтгэл санааг нь дэмжих, халамж анхаарал тавих талаар гэр бүл рүү чиглэсэн мэдээллийн постер бэлтгэж, олон нийтэд түгээсэн.
2. “Угийн бичиг хөтлөхийн ач холбогдол” сэдэвт цахим сургалтыг Зуунмод сумын “Унагалдайн андууд цэцэрлэг”-ийн 21 ажилтан, албан хаагчдад 04 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан. Угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлэх зорилгоор “ТА ХЭДЭН ҮЕЭ МЭДЭХ ВЭ?” уралдааныг залуу гэр бүлийн дунд зарлан, удирдамж, зөвлөмжийг олон нийтэд сурталчлан ажиллаж байна.
3. Цар тахлын өвчлөл нэмэгдэж, Монгол улсын Засгийн газраас 14 хоногийн хатуу хөл хорио тогтоосон энэ үед бага насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр гэрт нь үлдээх, хүүхдийн ахуйн орчинд гарч болзошгүй осол, гэмтлийн шалтгааныг илрүүлэх, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн гишүүдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор “МИНИЙ ГЭР-АЮУЛГҮЙ ОРЧИН” эрсдэлийн үнэлгээг 6 бүлгийн 26 асуумжаар байгууллагуудын эцэг, эхийн зөвлөлөөр дамжуулан хийлгэсэн. Үнэлгээнд 15 сум, 63 байгууллагын 1277 ажилтан, албан хаагч хамрагдаж, 6195 эрсдэлийг илрүүлж, 3300 эрсдэлийг газар дээр нь арилгуулан, 2895 эрсдэлийг “БҮХ ХАЙРАА ГЭР БҮЛДЭЭ” 1 сарын аяны хүрээнд засаж, сайжруулах хугацаатай үүрэг даалгаврыг сумдад хүргүүлсэн.

Залуучуудын хөгжил, нийгмийн оролцоог хангах чиглэлээр:

1. Монгол банкнаас мөнгөний долоо хоногийг олон нийтэд таниулан сурталчлах хүрээнд зохион байгуулсан “Мөнгө ба түүний үүрэг” сэдэвт сургалтын сургагч багшаар ЗХТөвийн 2 албан хаагч бэлтгэгдэж, “Залуучуудад зориулсан санхүүгийн зөвлөгөө” сэдвээр 6 төрлийн постер боловсруулан байгууллагын пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд түгээн ажиллаж, 245 хандалт авсан.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар:

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ:

1. 2021 оны 4-р сарын байдлаар 1915 иргэнд 1990,7 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1297 иргэнд 425,2 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 1231 иргэнд 412,1 сая төгрөг, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж 2 иргэнд 2,4 сая төгрөг, алдарт эхийн одонтой 9069 эхэд 1191,3 сая төгрөг, 352 ахмад настанд 29,3 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, насны хишиг 5246 ахмадад 432,1 сая төгрөг, 120 хөгжлийн

бэрхшээлтэй иргэнд 10,1 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, хүнс тэжээлийн тусламж шаардлагатай 6585 иргэнд 313,6 сая төгрөг, жирэмсэн 1155 эхэд 105,1 сая төгрөгийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 4712 эхэд 835,1 сая төгрөгийн тэтгэмж, Өрх толгойлсон 307 эх /эцэг/-т 122,5 сая төгрөг, ихэр хүүхэд төрүүлсэн 5 ихэр хүүхэдэд 17,0 сая төгрөг, амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулалд 163 иргэнд 6,6 сая төгрөг, 33761 хүүхэдэд 13391,8 сая төгрөгийг тус тус олгосон.

Нийгмийн хөгжлийн чиглэлээр:

1. ДЗМОУБайгууллагын Төв ОНХХөтөлбөртэй хамтран зорилтот бүлгийн 50 иргэнд “Хадгаламжийн үнэ цэнэ”, өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг 35 иргэнд “Нэмүү өртөг”, цахим сургалтыг зохион байгуулж, нийт 85 иргэн хамруулсан.
2. “Төгсөлтийн аргачлал” төслийн 2021-2024 онд хэрэгжүүлэх аймгийн нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан Аймгийн ЗДЗөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр:

1. ХБХЭМБНХСкомиссын хурал 1 удаа хуралдаж 4 хүүхэд орсон. Үүнээс 3 хүүхдийн хөгжлийн бэрхшээл, байнгын асаргааг сунгаж, 1 хүүхдийн хөгжлийн бэрхшээл, байнгын асаргааг шинээр тодорхойлсон.
2. Байнгын асаргаа шаардлагатай ХБИргэдийг 6-н шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ 27-н сумын 204 иргэнд хийсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвд 27-н сумын 264 хүүхдийн судалгааг гаргаж хүргүүлсэн. Хөдөлмөр эрхлэлтийн тэргүүн туршлага сэтгүүлд тавигдах ХБИргэний мэдээлэл боловсруулж Бүрэн, Баянчандмань сумын хоёр иргэний материаллыг бүрдүүлж хүргүүлсэн.

Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, хүүхдийн мөнгө, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний хүрээнд:

1. Өрхийн мэдээллийн нэгдсэн санд шинэ төрсөн 96 хүүхдийг бичиг баримтад үндэслэн бүртгэж хүүхдийн мөнгөнд хамруулсан. Аймгийн хэмжээнд 0-18 хүртэлх насны 33761 хүүхэд 3,376,100,000 төгрөг зарцуулсан.
2. Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдах хүсэлт ирүүлсэн 43 өрхийн судалгааны мэдээллийг программд шивсэн. Судалгааны мэдээллээ зөрүүтэй өгсөн 5 өрхийн оноог бичиг баримтад үндэслэн баталгаажуулж оноог бодуулсан.
3. Аймгийн хэмжээнд нийгмийн халамж, нийгмийн даатгалын сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр авч буй 2830 иргэний өрхийн амьжиргааны түвшинг прораммаас шүүж тухайн хби иргэдийн амжиргааны түвшинг бүлгээр ангилсан судалгаа мэдээллийн санг үүсгэсэн.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан:

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 4-р сарын байдлаар өссөн дүнгээр 348 иргэн бүртгэгдсэнээс 112 иргэн анх удаа бүртгэлд хамрагдаж, 236 иргэн бүртгэлээ сэргээсэн. Шинээр 20 ажил олгогч байгууллага, иргэн бүртгэгдлээ.

Нийт 46 ажил олгогчийн 202 /4 сард 31/ сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг хүлээн авч 94 /4 сард 19/ иргэн ажилд зуучлагдлаа.

Нийтдээ 8 суманд 50 шинэ ажлын байрныг бүртгэн мэдээлснээс байнгын 46, улирлын 3, түр 1 шинэ ажлын байр бүртгэгдсэн.

Түр ажлын байранд ажилласан 723 иргэдийн мэдээллийг сумдаас авч мэдээллийн сан үүсгэлээ.

Ажилгүйдлийн тэтгэмжинд хамрагдах 46 иргэнд бүртгэлд хамрагдсан тодорхойлолтыг Нийгмийн Даатгалын Хэлтэст гаргаж өгсөн.

Сумдад хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг цар тахлын үед цахимаар иргэдэд хүргэх, ажлын байрны мэдээлэл цуглуулах зорилгоор 25 сумын Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн утсыг 340,0 төгрөгийн нэгжээр цэнэглэж зардлыг ХЭДСангаас зарцууллаа.

ЗХЭДХөтөлбөрийн хүрээнд ажил хайгч залуучуудын Хөдөлмөрийн зах заалд нэвтрэх чадварын үнэлгээ хийх **YESDESK.MN** цахим контентийг хэрхэн ашиглах талаар сургалтад хамрагдлаа.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих загвар төвд ажил хайгч 54 иргэн үйлчлүүлж мэдээлэл авсан. Үүнээс:

- Хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх чадварын үнэлгээг 27 иргэнд хийж, 17 залуучуудыг модуль сургалт хамруулж, 9 иргэнтэй хамтран хөдөлмөр эрхлэлтийн хувийн төлөвлөгөөг боловсруулан ажиллаж, 10 иргэнийг ажилд зуучлан оруулсан.

4-р сард Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн 3 иргэнд ажил хайгчийн үнэлгээг хийж, 2 иргэнд хувийн төлөвлөгөөг боловсруулахад зөвлөгөө өгсөн. Мөн 2 иргэнийг байнгын ажлын байранд /Тагнуулын хэлтэс, РТА эмийн сан/, 1 иргэнийг Тэнгэр агро ХХК-д ногоочноор улирлын чанартай ажлын байранд зуучилсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан :

Тайлант хугацаанд ХЭДСанд 58'717,2 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт, өссөн дүнгээр 206 иргэний 150314,2 мянган төгрөг төвлөрч эргэн төлөлтийн 78%-тай байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн ажлын байрны төлбөрт 4 сард орлого төвлөрөөгүй ба өссөн дүнгээр Уулс Заамар ХХК-аас 2 иргэний 7190,8 мянган төгрөг ХЭДСанд төвлөрсөн.

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн талаар:

Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл 2021.04.14-ний өдөр анхдугаар хуралдаанаа хийж Зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө болон ХЭДХөтөлбөрүүдийг орон нутаг хэрэгжүүлэх талаар хэлэлцэж тогтоол шийдвэрээ гаргалаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг, малжуулах арга хэмжээ, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ, Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн мэргэжил олгох түр сургалт зэргийг аймгийн хэмжээнд нээлттэй зарлаж, Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг Зуунмод суманд 6, Баянчандмань, Жаргалант, Батсүмбэр сумдад тус бүр 2, бусад сумаас 1 төслийг шалгаруулан санхүүжилтийг олгохоор шийдвэрлэлээ.

ХАБЭА-н салбар зөвлөлийг хуралдуулах ажлын талаар:

Аймгийн Засаг даргын 2021 оны №228 дугаарын захирамжаар ХАБЭА-н аймгийн зөвлөлийг 16 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, жилийн ажлын төлөвлөгөөгөө хэлэлцсэн. ХАБЭА-н хууль, дүрэм, журмыг сурталчилан хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, ажлын байрны соёлыг төлөвшүүлэх "Covid-19" цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор "Хямралыг урьдчилан харж, бэлтгэлтэйгээр даван туулья ХАБЭА-н тогтолцоог бэхжүүлье" сарын аяныг зарлан зохион байгуулан ажиллаж байна.

Аяны хүрээнд: Аймгийн болон сумдын зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг 3 удаа, төрийн байгууллагын үйлчилгээний албан хаагчдад мэдлэг олгох сургалтыг 1 удаа зохион байгуулж, сургалтын үйл ажиллагааг Төв ТВ-ээр шууд дамжуулан орон нутгийн иргэд, ААНБайгууллагын ажилтнуудад үзэх боломж олгосон.

Эрүүл мэндийн салбар:

1. Аймгийн удирдах ажилтны зөвлөгөөнд эрүүл мэндийн чиглэлээр 2021 онд анхаарах асуудлын талаар мэдээлэл бэлтгэн илтгэл тавьсан.
2. ЭМЯ, ХӨСҮТ-ээс зохион байгуулж байгаа цахим хуралд 5 удаа оролцож, мэдээллийг холбогдох мэргэжилтнүүд, ЭМБ-уудад цахимаар 3 удаа зохион байгуулсан

3. Бүх хэлтэс, төвийн албан хаагчдын 2021 оны 1-р улиралд хийсэн ажлын тайлангаа илтгэх хуудсаар авч, удирдлагын зөвлөлөөр хэлэлцэн дүгнэсэн.
4. **“Зөв хандлага-Эерэг нөлөө”** 1 сарын аяны хүрээнд “ТАХ-ын ёс зүй, харилцаа хандлага” сэдэвт сургалт 2021 оны 04 сарын 16-ны өдөр ЭМГ-ын сургалтын танхимд зохион байгуулагдан, ЭМГ-ын дарга, хэлтсийн дарга нар, мэргэжилтэн, ажилтнууд нийт 30 гаруй хүн оролцлоо. Хөтөлбөрийн дагуу МУЗГ-ын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” баримтлах ёс зүйн хэм хэмжээг танилцуулж, шинээр ажилд орсон 1 ажилтнаар ёс зүйн баталгаа гаргуулж, гарын үсгээр баталгаажууллаа. Байгууллагын “Ёс зүйн зөвлөл”-ийн бүрэлдхүүнийг хамт олны саналыг авч, 3 хүний бүрэлдхүүнтэй шинэчлэн байгууллаа. Энэхүү үйл ажиллагаа нь байгууллагын нийт ажилтнуудын оролцоог хангасан, шинэлэг хэлбэрээр, сонирхолтой аргаар зохион байгуулсан, үр дүнтэй арга хэмжээ боллоо.
5. ЭХЭМҮТ-ээс зохион байгуулсан Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах 2 өдрийн цахим сургалтад хамрагдан, “Өсвөр үеийн эрүүл мэнд” 7 хоногийн аяны үйл ажиллагааг зохион байгуулж байна.
6. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн салбар хорооны 2021 оны төлөвлөгөөнд тусгах саналаа хүргүүлж, аймгийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар хорооны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, 2021 оны төлөвлөгөө танилцуулах цахим хуралд хамрагдсан.
7. 2021 оны 04 сарын 01- 09-ны өдөр Зуунмод сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг стратегийн ач холбогдол бүхий байгууллагуудын нийт 855 албан хаагчдыг Синофарм компани Вероцел вакцины 1-р тунд хамруулсан.
8. 2021.04.24-25-нд аймгийн хэмжээнд 5901 тун Синофарм компани Вероцел вакциныг 27 суманд хуваарилан хүргэж, Зуунмод суманд нийт 699 хүнийг 2-р тун, 29 хүнийг 1-р тун вакцинд нийт 728 хүнийг вакцинжуулах ажлыг зохион байгууллаа. 25 суманд вакцины 2-р тунг 3 ажлын хэсэг гарган 2 өдрийн турш тарааж, хүйтэн хэлхээг алдагдуулахгүйгээр хүлээлгэн өгсөн. Мөн сум бүрт /нэг суманд халад-80 ширхэг, нүүрний хаалт-40 ширхэг, бээлий-400 ширхэг, нэг удаагийн амны хаалт-80 ширхэг, хогийн шар уут-8 ширхэг, санитол-1.2 литр/-ийг хүргэн өгсөн.
9. Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн вирус судлалын лабораторид б/х-ПГУ шинжилгээнд нийт 12123 сорьцыг зөөвөрлөн хүргэсэн. 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш нийт 528 батлагдсан тохиолдлыг тандалтаар илрүүлэн яаралтай эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж ажилласан.
10. Аймгийн хэмжээнд Зуунмод сумын ӨЭМТ, 26 сумын Эрүүл мэндийн төв, аймгийн Нэгдсэн эмнэлэгт COVID-19 антиген илрүүлэх түргэвчилсэн оношлуураар 04 сард 3348 иргэнд түргэвчилсэн оношлуураар шинжилгээг гүйцэтгэсэн. Түргэвчилсэн оношлуур 2000 ширхэгийг татан авч сумдад хуваарилсан.
11. 2021.04-р сарын байдлаар 134 иргэнийг тусгаарлан ажиглах байранд авч ажилласнаас 28 иргэнд Коронавирусын халдвар илэрсэн.
12. Аймгийн хэмжээнд гэрийн тусгаарлалтад нийт 5105 иргэнийг хяналтад авснаас, 2021 оны 04 дугаар сард 3156 иргэнийг гэрийн харъяа ЭМБ-ууд хяналт тавин ажилласан. Өнөөдрийн байдлаар 1537 иргэнд хяналт тавин ажиллаж байна.
13. Коронавируст /ковид-19/ халдвар бүртгэгдсэн Жаргалант, Баянцагаан, Баянчандмань, Мөнгөнморьт сумдад ажлын байран дээр эмнэлэг дэлгэх зураглал, шаардлагатай ХХХХ, Хоол хүнс, эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоолол судалгаа гаргаж сумын Онцгой комисст санал хүргүүлж, утсаар холбогдон байнга мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна.
14. ЗХӨТСТ-ийн тандалт хариу арга хэмжээний багаас 154 өвчний голомтод 81 объект, халдвар батлагдсан 49 айл өрхөд голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг 29225 мкв талбайд гүйцэтгэн ажилласан.
15. ЭМС-ын 2021 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн А/202 дугаар тушаалаар 8 сумын ЭМТөв, 1 өрхийн Эрүүл мэндийн төв 1 жилээр магадлан итгэмжлэгдсэн. Шийдвэрийг ЭМБ-уудад, аймгийн ЭМДаатгалын тасагт хүргэсэн.

16. Сумын 2 иргэний гаргасан гомдлын мөрөөр Баянчандмань суманд ажиллаж, сумын удирдлагууд болон холбогдох иргэнтэй уулзаж, 1 гомдлыг газар дээр нь шийдвэрлэн ажилласан.
17. ЭХЭМҮТ-ийн Сургалт, сурталчилгааны албанаас хүргүүлсэн Шинэчилсэн ХӨЦМ-2020 хүснэгтэн тохимолыг АНЭ, өрх, 26 СЭМТ-д цахимаар хүргүүлсэн.
18. Энэ сард “ЭНТО ХХК-аас 1,100,000 төгрөгийн вакуум тейнер, “МОНОС ТРЕЙД ХХК”-аас 34,500,000 төгрөгийн түргэвчилсэн оношлуур татан авсан. 8,260,000 төгрөгийн үнэ бүхий оношлуур Өндөр Довын пост, АНЭ, СЭМТ –үүдэд олгосон. Мөн 13,640,000 төгрөгийн түргэвчилсэн оношлуурыг падаан фактурын хамт түгээсэн.
19. ЭМЯамнаас вирусийн эсрэг эм 13200 ширхэг арбидолыг татан авч, Нэгдсэн эмнэлгийн эмчилгээнд ашиглаж байна.
20. Цахим тендерийг 12 багцад зарлан, тендерийн үйл ажиллагаа нээгдсэн. Тендерийн 23 багцад шалгарсан 12 компанитай гэрээ байгуулж дууссан.

Зургаа. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:

Төсвийн орлогын талаар:

Орлогын төлөвлөгөө эхний 3-р сарын байдлаар орон нутаг 1060.9 сая төгрөг төвлөрүүлэхээс 1262.5 сая төгрөг төвлөрүүлж 119.0 хувьтай, 201.6 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө давж биелсэн байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 4228.4 сая төгрөг төвлөрүүлэхээс 4589.9 сая төгрөг төвлөрүүлж 108.5 хувьтай, 361.4 сая төгрөгөөр давж биелсэн. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 781.7 сая төгрөгөөр биелж, 112.1 %-тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Батсүмбэр, Баянхангай, Баянцагаан, Баянцогт, Жаргалант, Мөнгөнморьт, Угтаал зэрэг 7 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Алтанбулаг, Аргалант, Архуст, Баянчандмань, Заамар, Өндөрширээт, Сэргэлэн, Сүмбэр, Цээл, Эрдэнэсант, Зуунмод зэрэг 11 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Баян, Баяндэлгэр, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Борнуур, Дэлгэрхаан, Эрдэнэ зэрэг нийт 7 сум байгаа ба 3 шатны орлогын төлөвлөгөө тасалсан Бүрэн, Лүн сум байна.

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

Сумдад 2021 оны 3 сарын байдлаар нийт 19199,2 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

Салбараа авч үзвэл:

Боловсрол шинжлэх ухааны сайдын багцаас 9277,8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуулиудад 5944,7 сая төгрөг
- Хүүхдийн цэцэрлэгт 3333,1 сая төгрөг тус тус олгоод байна.
- Эрүүл мэндийн сайдын багцаас 2501,5 сая төгрөгийг олгосон.Үүнд:
- Сумдын эрүүл мэндийн төвд 2397,8 сая төгрөг
- Өрхийн эмнэлэгт 103,7 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.

Газрын харилцаа,барилга хот байгуулалтын газарт 146.2 сая төгрөг, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газарт 77.3 сая төгрөгийн зарлага санхүүжилт тус тус олгоод байна.

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 7196,4 сая төгрөгийн санхүүжилт олгосон.Үүнээс:

- Сумдын ИТХ,ЗДТГазар, Соёлын төвүүдийн санхүүжилтэд 4798.7 мянган төгрөг
- Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 2397,7 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна.

Өр, авлагын талаар:

2021 оны 3-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгууллагууд нийт 164446.3 мянган төгрөгийн авлага, 401700.5 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 141246.9 мянган төгрөг буюу 35.2 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг 49146,5 мянган төгрөг буюу 12.2 хувь нь цалингийн өглөг, 16586.5 мянган төгрөг буюу 4.1 хувь нь НДШимтгэлийн өр, 19004.3 мянган төгрөг буюу 4.8 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, үлдсэн 175716.3 мянган төгрөг буюу 43.7 хувийг бусад өр эзэлж байна

Долоо. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:*Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:*

Засгийн газрын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2021 оны 1 дүгээр улирлын тайланг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан /www.new.unelgee.gov.mn /-д 76.25 хувьтай тайлагналаа.

Хэрэггжилт гаргах нийт заалтын тоо		16
Бүрэн хэрэгжсэн	100%	6
Хэрэгжих шатанд	70%	8
Хэрэгжилт хангалтгүй	30%	2
Хэрэгжээгүй	0%	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	-
Хэрэгжилтийн дундаж		76.25%

Төлөвлөлт, гүйцэтгэл, Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сургалтад хэлтсийн мэргэжилтнүүд амжилттай хамрагдаж сертификатад авлаа.

Төв аймгийн Засаг даргын Тамгын газар, ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс болон “Ухаалаг засаглал” төрийн бус байгууллагатай хамтран 27 сумын Засаг даргын Тамгын газрын дарга нар болон, Хууль эрх зүйн мэргэжилтэн / 54 албан хаагч / нарт “Бодлогын баримт бичгийг цахим санд оруулах” тухай цахим сургалтыг амжилттай зохион байгууллаа.

2020 баримтад техник боловсруулалт хийн 59 хадгаламжийн нэгж үүсгэж архивт тушаалаа.

Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр:

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны төлөвлөгөөний дагуу

Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад сумдын Сум хөгжүүлэх сан, эргэлтийн эмийн сан, Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, Мал хамгаалах сангийн 2017-2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, Зуунмод сумын хот тохижуулах газар, БОАЖГ, Лүн сум дахь ойн анги, Төв аймгийн Орон нутгийн өмчийн гаар, Статистикийн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтсийн 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 221.643.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 58,498.0 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт, 163.145,5 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага тогтоож ажиллав. Улсын байцаагчийн тогтоосон актаас 6.5 мянган төгрөг барагдсан байна.

Найм. Цэргийн штабын хүрээнд:

1.Орон нутгийн удирдах ажилтны нэгдсэн зөвөлгөөнд ЗДТГ-ын Цэргийн штаб дарга, дэд хурандаа Т.Төмөрчөдөр “Орон нутагт батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нь” сэдвээр мэдээлэл хийлээ. Уг сэдвийн хүрээнд Цэрэг татлагыг цар тахалын үед хэрхэн зохион явуулахад бүх шатны Засаг дарга нарын үүрэг оролцоо, Цэргийн албанд татагдсан залуучуудыг Засгийн газрын 2019 оны 441 дүгээр тогтоолоор батлагдсан эрүүл мэндийн 8 төрлийн шинжилгээг бүрэн хийлгэх, Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах журмын хэрэгжилтийг хангах, “Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд сум орон нутагтаа хүүхэд залууст чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион явуулах, Цэргийн штабаас 2021 онд зохион явуулах сургалтуудын талаар үүрэг чиглэл өглөө.

2. Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, зорилгоор цахим уулзалтыг зохион явууллаа. Төв аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб нь Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл, Зэвсэгт хүчний 232 дугаар ангид 2020 оны 2 дугаар ээлжээр цэргийн албанд татагдсан Зуунмод, Архуст, Баянчандмань, Батсүмбэр, Борнуур, Батсүмбэр, Баянжаргалан, Баян Жаргалант,

Мөнгөнморьт, Эрдэнэ сумдын дайчдыг цахимаар болон утсан холбоогоор аав, ээж, ах, дүү нартай нь холбогдуулах ажлыг анги, нэгтгэлийн удирдлага хамт олонтой хамтран зохион явуулсан.